

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +22
Шөнө +11

ҮЛС ТӨР

Э.АМАРБАТ: МАН-ЫН 60 ТЭРБУМ ТӨГРӨГТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛД ЭРҮҮ ҮҮСГЭХЭЭС ТАТГАЛЗСАН

II нүүрт

ХЭН НЬ ХЭН БЭ

ЗАСАГ ДАРГААС ЕРӨНХИЙ САЙД

V нүүрт

Дугаарын **60** мөр

Аялах сайхан ч амрах газар олдохгүй нь ээ

ҮЗЭЛ БОДОЛ

М.ЭНХБОЛД МАН-ЫН “ТОЛГОЙ” ДЭЭР САНДАЙЛЖ, З.ЭНХБОЛД АН-ЫН “ХӨЛ”-ӨӨС ЗУУРСААР...

Ж.ОТГОНМЯГМАР

Аялал жуулчлалаар бид мөнгө олж чадахгүй байсаар чамгүй хугацааг өнгөрөөсөн. Гэхдээ сүүлийн хэдэн жил дотоодын аялал жуулчлалын үзүүлэлт эрс өсч байгаа. Зуны улиралд амралтаа авсан хүн бүр Монгол орныхоо үзэсгэлэнт, үүх, түүхийн өлгий нутгаар аялан, амарч зугаалдаг болоод байна. Бүр хөдөөгийн замд түгжрэл үүсэх хэмжээнд аялж, зугаалж байгаа. Ялангуяа Хөвсгөл далай, Тайхар чулуу, Хамрын хийд, Ээж хад, Сайханы хөтөл, Аглаг бүтээлийн хийд зэрэг хүн бүрийн очиж үзэхийг хүсэх болсон газрууд одоо ч дотоодын аялагчдын хөлд дарагдсаар байна. Тиймээс аялал жуулчлалд зориулаад хөгжүүлчихэд нэг их хэцүү ажил биш санагдана. Гэвч хөдөө нутаг руу хулгийн жолоо залсан хүмүүст нүд баясгах сайхан байгалиас өөр гялтайх зүйл огт алга.



Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын ээлжит сонгууль болж, МАН үнэмлэхүй ялалт байгуулснаас хойш хоёр сар өнгөрөх гэж байна. Энэ удаагийн сонгуульд гурван нам л сандал суудал “зулгааж” чадсан. МАН итгэмээргүй ялалт байгуулж, АН арай гэж бүлэг байгуулах хэмжээний суудал авсан бол МАХН-ын нүүрийг О.Баасанхүү тахалсан билээ. Сонгууль дууссанаас хойш УИХ-д суудалтай гурван нам өөр өөрийн өнгө төрхтэй байна. Энэ тухай товч сийрүүлбэ.

М.Энхболд дараагийн Н.Энхбаяр болж байна гэнэ

Үнэмлэхүй ялалт байгуулж, “сүүл” өөдөө болсон МАН-ынхан Засгийн газраа эмхлэн байгуулж, эхнээсээ “самарч” л байна. Мэргэжлийн Засгийн газар байгуулна гэж мөрийн хөтөлбөртөө тусгаж, энэ тухай ам мэдэн хашгирагдаж байсан Ардын намынхан сонгуульд ялалт байгуулсныхаа дараа л “сүүлээ шарваж”, ард түмнээр тохуурхаж эхлэв. Юун мэргэжлийн Засгийн газар, харин ч мөнгөөр албан тушаал худалдаж авагсдаас бүрдлээ гэж олон хүн дүгнэж байна. Угаасаа нэг их дүгнээд байх ч хэрэггүй. Нүдэнд харагдаж байхад. Тиймдээ ч энэ Засгийн газар дорвитой ажил хийхийн оронд АН-ын эрх барьсан дөрвөн жилийг харлуулах гэсэн ганц чигийг л барьж ажиллаж байгаа гэхэд хилсдэхгүй. Сангийн сайд нь “Монгол Улс сүйрч байна” гэж ирээд л сүртэй мэдэгдэл хийж, зурагтаар төлбөртэй нэвтрүүлэг цацуулж, эх орныхоо нэр нүүрийг дэлхий дахины өмнө “түлж” ч байх шиг. Ерөнхий сайд нь зардлаа танахын тулд төрийн албан хаагчдын цалинг хасна, хүүхдийн мөнгийг олгохгүй, ялгаж салгана ч гэж үзэв.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

УУЛЫН БАЯЖУУЛАХ “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ БИЕЛҮҮЛЖ, АШИГТАЙ АЖИЛЛАЛАА



2016 оны эхний хагас жилийн байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК үйлдвэрлэлийн төлөвлөгөөг бүх үзүүлэлтээ давуулан биелүүлж ажиллалаа. Төлөвлөгөөнөөс 229.0 мянган. тн хүдэр илүү боловсруулж, ээс - 3340.27 тонн, молибден - 360.7 тонныг тус тус нэмж үйлдвэрлэлээ. Мөн 2016 оны эхний хагас жилд баяжмалын үйлдвэрлэлийг давуулан биелүүлснээр 32.6 тэрбум төгрөгийн орлогыг нэмж олсон боловч, төгрөгийн доллартай харьцах ханшийн сулралтаас 4.7 тэрбум төгрөг, баяжмалын борлуулалтын үнийн уналтаас 44.5 тэрбум төгрөгөөр орлого буурсан.

Хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэн ажилласны үр дүнд тайлант хугацаанд нийт зардлыг 62.0 тэрбум төгрөгөөр хэмнэж, нэг тн цэвэр эзсийн тооцоот өртгийг 4023.63 ам. долларт хүргэж төлөвлөгөөнөөс 878.06 ам.доллаароор, өнгөрсөн оны мөн үеэс 1176.37 ам. доллараар тус тус бууруулсан амжилттай ажиллалаа. 2016 оны эхний хагас жилд “Эрдэнэт үйлдвэр” ХХК 32.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, улсын ба орон нутгийн төсөвт нийт 71.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Дашрамд дурьдахад, эзсийн үнэ буурч үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж байсан хэдий ч Уулын баяжуулах “Эрдэнэт

үйлдвэр” маань 2013-2015 онд нийт 3.6 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, төлөвлөгөөгөө биелүүлснээс гадна нийт 127.9 тэрбум төгрөгийн нэмэлт орлого олж, 131.6 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн амжилттай ажиллажээ. Сүүлийн жилүүдэд компанийн гүйцэтгэх удирдлага нэг тонн цэвэр эзсийн тооцоот өртгийг тогтмол бууруулах бодлого баримталснаар 2016 оны эхний зургаан сарын байдлаар нэг тонн цэвэр эзсийн тооцоот өртөг 4023.6 ам.доллар болж буурсан нь 2012 онтой харьцуулахад, 2833.7 ам.доллаароор буурсан үзүүлэлт ажээ.

VERTUL®
АЛБАН ТАСАЛГААНЫ ТАВИЛГА - ГАЛЛЕРЕЙ

ИТАЛИ АЛБАН ТАСАЛГААНЫ ТАВИЛГА

АГУУЛАХ ЧӨЛӨӨЛӨХ ХУДАЛДАА

50% OFF

Хэмжээний сонголт: 206x90x45, 136x90x45, 85x90x45
Өнгөний сонголт: цагаан, шар

Хаяг: Хүнсний 4 дэлгүүрийн ард, PC mall дэлгүүрийн 3 давхарт, Вертул ХХК
Холбоо барих утас: **7575-3535**

ХААН Банк					Хугалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах	Авах	Зарах		Авах	Зарах	
АМ.ДОЛЛАР	2240.00	2263.00	ФУНТ	2869.00	2987.00	АМ.ДОЛЛАР	2242.00	2263.00	ФУНТ	2890.00	3013.00
ЕВРО	2498.00	2582.00	РУБЛЬ	32.90	37.30	ЕВРО	2500.00	2608.00	РУБЛЬ	33.94	37.49
ИЕН	22.07	22.92	ЮАНЬ	338.00	345.40	ИЕН	22.11	23.15	ЮАНЬ	338.30	345.90

УЛС ТӨР

Ж.ОТГОН

УЕП-ын газраас энэ оны эхний долоон сарын ажлын тайлан мэдээлэл болон олны анхаарлын төвд байгаа хэргүүд болон хэрхэн шийдвэрлэгдсэн талаар мэдээлэл өглөө. Мэдээллийг УЕП-ын туслах, Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дарга Э.Амарбат болон Нийслэлийн прокурорын газрын прокурор Г.Бясман нар өгсөн юм.

МАН-ынхны бичлэгийг эвлүүлэг хэмээн дүгнэжээ

Сонгуулийн өмнө МАН-ын удирдлагуудтай холбогдох 60 тэрбум төгрөгтэй холбоотой бичлэгийг үндэслэн АН-ын удирдлагууд хууль хяналтын байгууллагад шалгуулах хүсэлт гаргасан. Улмаар УЕП-ын туслах Э.Амарбатад шалгуулах хүсэлтээ хүргүүлсэн билээ. АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Эрхэмбаяр тухайн үед “МАН-ын удирдлагууд төрийн албыг хэрхэн наймаалцаж, үнэлсэн талаарх ноцтой баримтуудолдсон. Энэ асуудлыг зохих хуулийн байгууллагаар шинжлүүлэхэд тэдний яриа мөн болох нь нотлогдсон. Тиймээс УЕП болон ТЕГ, АТГ, ЦЕГ-г хандан, энэхүү асуудлыг үргэлжлүүлэн шалгахыг хүсч мэдээлэл хүргүүлж байна” гэдгээ мэдэгдэж байсан. Тэгвэл уг асуудлыг УЕП-аас шалгасан талаараа Э.Амарбат “АН-ын дарга З.Энхболдын гаргасан гомдлыг манайх хүлээж аваад харьяаллынх нь дагуу АТГ-д шилжүүлсэн бөгөөд тэндээс уг асуудлыг хянаж үзээд шүүх шинжилгээний үндэсний



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Э.АМАРБАТ: МАН-ЫН 60 ТЭРБУМ ТӨГРӨГТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛД ЭРҮҮ ҮҮСГЭХЭЭС ТАТГАЛЗСАН

хүрээлэнгээс зохих шинжээч мэргэжилтэн томилж, уг бичлэгийн асуудлаар дахин дүгнэлт гаргуулсан байна. Уг дүгнэлтээр бичлэг нь эвлүүлэг байна гэж гарсан. Хоёрдугаарт, шалгалтын явцад уг яриатай холбоотойгоор аль нэг төрийн болон нийслэлийн байгууллагад хэн нэгнийг албан тушаалд томилж зорилгоор бусдаас хууль бусаар хөрөнгө мөнгө цуглуулсан, төвлөрүүлсэн асуудал тогтоогдоогүй. Ийм учраас уг асуудалд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан юм”

гэлээ.

МАХН-ын дарга Н.Энхбаярыг яллагдагчаар татжээ

МАХН-ын дарга Н.Энхбаярыг яллагдагчаар татжээ. Түүнийг худалдан авах гэрээгээр халхавчилж бусдын объектийг үнийн зарим хэсгийг төлөөгүй залилан мэхэлсэн, бусдыг хээл, хахууль авахад хамтран оролцож өдөөн түлхсэн, гүйцэтгэх ажлын хууль

тогтоомжийг зөрчсөн зэрэг хэргүүдэд яллагдагчаар татан шалгаж байгаа аж. Мөрдөн байцаах ажиллагаа дуусах шатандаа явж байгаа гэнэ. Хуулийн байгууллагаас Н.Энхбаярыг долоон удаа дуудсан ч өмгөөлөгч байхгүй гэх шалтгаанаар ирээгүй байна. Уг нь тухайн хүн өмгөөлөгчгүй байсан ч заавал ирэх үүрэгтэй байдаг. Харин ирсэн хойно байцаалт өгөхгүй байх нь тухайн хүний эрхийн асуудал байна. Тиймээс цашид мөрдөн байцаах ажиллагаанд

Н.Энхбаярыг өмгөөлөгчгүй гэх шалтгаанаар саад учруулахгүй байх нь зүйтэй гэдгийг онцолж байлаа.

С.Зоригийн хэрэгт Б.Булганаас гадна нэг бус хүнийг сэжигтнээр татсан гэв

Улс төрийн нэрт зүтгэлтэн С.Зориг агсныг хөнөөсөн хэрэгтэй холбогдуулан түүний

эхнэр Б.Булганыг цагдан хорьж шалгаж эхэлснээс хойш есөн сарын хугацаа өнгөрөөд байна. Б.Булганд холбогдох хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа үргэлжилсэн хэвээр буйг өнөөдөр Улсын ерөнхий прокурорын туслах, хэлтсийн дарга Э.Амарбат мэдээллээ. Прокурорын байгууллагаас хийсэн тайлбараар С.Зориг агсныг хөнөөсөн хэрэгт Б.Булганаас гадна нэг бус хүнийг сэжигтнээр татаж, саатуулан байцааж эхэлжээ. Гэхдээ дээрх хэрэг нь нууцны зэрэгтэй учраас үүнээс илүү мэдээлэл өгөхгүй гэдгийг учирласан юм. Дашрамд дуулгахад, Б.Булганд Төв аймгийн цагдан хорих төвд ганцаарчлан хорьж байгаа бөгөөд өмгөөллийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа аж.

А.Гансүхийг сэжигтнээр татаж, хилийн хориг тавьжээ

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газар, Авилгатай тэмцэх газраас хамтарсан ажлын хэсэг гарч, Гашуун сухайт-Ухаа худаг чиглэлийн 267 километр төмөр замтай холбоотой хэргийг шалгаж байгаа билээ. Одоогоор мөрдөн байцаалтын ажиллагаа дуусаагүй, үргэлжилж буйг нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор Г.Бясман мэдэгдлээ. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулах гэж зааснаар УИХ-ын даргын зөвлөх асан А.Гансүхийг сэжигтнээр татаж, мөрдөн байцаалтын ажиллагааг үргэлжлэн явагдаж байгаа аж. Мөн А.Гансүхийн хилийн хориг тавьсан байна.

MINFO

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:

С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч:

Ч.ЧУЛУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:

Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба:

Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:

Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:

Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:

Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:

Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:

М.ДАВААДУЛАМ
99042510Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн

Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/,
2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редактор эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Намын шинэчлэл шийдэл сэдвээр хэлэлцүүлэг болно

Ардчилсан намын шинэчлэлийн ажлыг хэсгээс “Улс төрийн намын шинэчлэл, шийдэл” сэдвээр эрдэмтэн судлаачидтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулахаар болжээ. Хэлэлцүүлэг өнөөдөр Сонгуулийн Ерөнхий хорооны дугуй зааланд 14:00 цагаас эхлэх гэнэ. Энэхүү хэлэлцүүлэгт эрдэмтэн судлаачид илтгэл тавьж,

улс төрийн намын шинэчлэлийн асуудлаар нийгэмд тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдэх шийдлүүд, улс төрийн намын тухай хуулийн төсөл, нээлтэй ил тод байдал, гишүүнчлэл гэх мэт өргөн хүрээний сэдвүүдээр хэлэлцэх төлөвлөөд байгаа аж. Уг хэлэлцүүлэгт улс төрийн намуудын төлөөллийг нээлттэй оролцож болох юм байна.

Гадаад паспорт олголт тойрсон хүндрэлийг шийдэх нь

Гадаад паспортыг олгохгүй, паспорт хүссэн хүсэлтийг ирэх есдүгээр сар гартал хүлээж авахгүй байгаа талаар иргэдээс Засгийн газрын шуурхай мэдээллийн 11-11 төвд олноор хандаж байна. Иймд гадаад паспорт олголтыг тойрсон хүндрэлтэй асуудлыг шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад хэргийн сайдын тушаалаар байгуулахаар боллоо. Уг нь 2016 оны улсын төсөвт 150 мянган ширхэг үндэсний энгийн гадаад паспортын бэлдэцийн зардалд 850 сая төгрөг төсөвлөжээ. Гэвч дээрх санхүүжилтийг 2015 онд нийлүүлсэн гадаад паспортын төлбөр болон шинээр нэвтрүүлэх чигтэй гадаад паспортын бэлдэцийн санхүүжилтийн урьдчилгаанд тус тус шилжүүлсэн байна. Ингэснээр гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэгч компанид бэлдэцийн байнгын өр төлбөр үүсч, урьд өмнөх онуудын өр төлбөрийг 2016 оны

төсвийн санхүүжилтээс шилжүүлэн өгсөн байна. Өөрөөр хэлбэл, гадаад паспортын бэлдэцгүй биш, харин бэлдэц худалдан авах 2016 оны төсөв нь дууссан учраас өнөөдрийн хүндрэл үүсээд байгаа юм байна. 2016 оны долдугаар сард 160 мянган ширхэг бэлдэцийг худалдан авах гэрээ байгуулжээ. Үүнээс энэ сарын 9-ний байдлаар 4500 ширхэг бэлдэцийг хүлээн авснаас одоогоор 3837 ширхэгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд энэ нь ердийн үеийн гурван өдрийн хэрэгцээ юм. Засгийн газрын зүгээс өр төлбөр, санхүүгийн асуудлыг жаралтай шийдвэрлэж, гадаад паспортыг цаашид хүндрэл үүсгэхгүйгээр олгох зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. Энэ наймдугаар сард худалдан авах бэлдэцийн төлбөрийг Засгийн газар шийдэж, харин үлдэгдэл бэлдэцийг худалдан авах санхүүжилтийг 2016 оны улсын төсвийн тодотголд оруулж шийдүүлэх юм.

АН-ын бүлэг чуулган хуралдуулахыг шаардав

УИХ дахь АН-ын бүлгийн дарга С.Эрдэнэ УИХ-ын ээлжит бус чуулганыг нэн даруй хуралдуулахыг шаардсан албан бичгийг УИХ-ын дарга М.Энхболдод хүргүүлжээ. Шаардлагад Ерөнхий сайд болон Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгч нарын

эдийн засгийн нөхцөл байдлын талаар хийсэн мэдэгдэл нь тооцоо судалгаагүй, бодит үнэнд нийцээгүй, нэг талыг барьсан, хууль зөрчсөн, эдийн засагт сөрөг нөлөөтэй, иргэдийг төөрөгдүүлсэн, гадаад дотоод хөрөнгө оруулалтад ноцтой хохирол учруулсан

үйлдэл болсон. Иймд УИХ-ын чуулганыг хуралдуулж, дээрх албан тушаалтнуудад хариуцлага тооцох болон улсын нэгдсэн төсвийн орлогыг нэмэгдүүлж зарлагыг бууруулах тухай асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэж онцолсон байна.

“Сайн хөтөлбөр”-ийг зогсоосонд малчид бухимдалтай байна



УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат орон нутагт ажиллаж байна. Тэрбээр Архангай, Булган аймагт ажиллалаа. Энэ үеэр Ардчилсан намын гишүүд, дэмжигчид, малчид, иргэдийн зүгээс “Сайн малчин”, “Сайн оюутан” хөтөлбөрүүдийг зогсоох шийдвэрийг Мэргэжлийн Засгийн газар гаргасан нь үнэхээр зогсоох аргагүйд хүрсэн, эсвэл улстөржиж Ардчилсан намын хөтөлбөр гэдгээр зогсон эсэхт хариулт өгөхийг хүслээ. Түүнчлэн дээрх хөтөлбөр хэрэгжих ёстой гэдгийг хэлж байлаа. Тэдний энэхүү асуултад УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат “Ардчилсан нам өнгөрсөн дөрвөн жилд асар их зүйлийг хийсэн. Эдийн засгийн хүндрэл, бэрхшээл олон зүйлийг хийхэд чөдөр болж байсан ч хийж чадсан. Ер нь эдийн засгийн хүндрэл, эдийн засгийн хөгжил

нь аль улс төрийн хүчин Засгийн эрхийг барьж байна вэ гэдгээр ялгаварладаггүй юм. Гэтэл Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд нарын хийсэн хариуцлагагүй мэдэгдэл нь бондын хүүг өсгөж, валютын ханшийг савлуулж, эдийн засагт итгэх итгэлийг унагалаа. Монголбанкны ерөнхийлөгч балансын тоог хасах болгож хэлсэн бол Сангийн сайд төсвийн орлогыг зохиомлоор бууруулж, төсвийн зарлагыг зохиомлоор өсгөсөн нь маш хариуцлагагүй мэдэгдэл. Ерөнхий сайдын мэдэгдэл нь мөн амлалтынхаа эсрэг явлаа. Цалинг бууруулна, зарим халамжийг зогсооно, бүсээ чангална гэлээ. Ингэх байсан юм бол яах гэж амлалт өгсөн юм. Уг нь “Сайн хөтөлбөр”-үүд төрд ачаалал үүсгэхгүй хөтөлбөр байсан. Бонд гаргаад хэрэгжиж байсан хөтөлбөр” хэмээн хариулсан юм.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Аялах сайхан ч амрах газар олдохгүй нь ээ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Аялагчдад зориулсан ямар нэгэн үйлчилгээ тэнд байхгүй, хөдөөгийн иргэд нь зөвхөн ашиг олохыг илүүд үздэг болсон монголоо алдсан хачин зантай болчихсон байх юм. Нөгөө Ц.Чимиддорж гуайн “Малчин” шүлэгт гардаг шиг “Давхиад буухад цоожгүй айл малчин таных Даянд ганцхан цуургагүй сэтгэл малчин таных... гэдэг шиг халуун дотно сэтгэлтэй байхгүй юм аа гэхэд аялагчдын “халаасыг сэгсрэхдээ” аятайхан үйлчилдэг болмоор юм. Шуудхан хэлэхэд, өвөлжин хотын утаанд туйлдтал ажилласан нийслэлчүүд зуны дэлгэр цагт хөдөө гадаа гарч, уушгиа баярлуулангаа байгалийн сайхан хэд хоног амарч тухлахыг эрхэмлэн амралтынхаа хэд гурван төгрөгийг аваад л гарч байгаа. Өөрөөр хэлбэл, нийслэлийн нэг айл гэхэд л хөдөө орон нутагт очиж багадаа нэг сая төгрөг цагчихаад ирдэг. Харин үүний хариуд өт, ялаандаа идэгдсэн бие засах газар, архи, шээсний үнэр нэвт шингэсэн гэр буудал угтаж байна. Малчид нь тэнгэрт хадсан үнээр хонь малаа зарж, айраг цагаагаа усаар “арвижуулж” арай хэтэрсэн үйлдэл гаргасаар байх юм.

Манай орон уудам дэлгэр нутагтайг ч хэлэх үү нэг газарт очих гэж багадаа 500 км зам туулах болдог. Энэ нь машинаар 5-6 цаг зогсолтгүй давхиж байж очно гэсэн үг. Тиймээс ч замдаа хэд хэдэн удаа зогсч бие засах, хооллож ундлах шаардлагатай болдог. Гэтэл замын цайны газар гэхэд л үйлчилгээ маш тааруу хэрнээ дээд “зэрэглэлийн” их зантай, ааш аягтай байх нь эмгэнэлтэй.

Саяхан миний бие дэлхийд байдаг энергийн хоёрхон төвийн нэг болох Хамрын хийдийг зорив. Гэтэл замдаа зогсоод хоол идэх тухтай газар ганц ч таарсангүй. Тиймээс хоосон давхсаар Дорноговь аймгийн төв Сайншандад очтол шөнө болсон учир хооллох газар мөн л олдсонгүй. Өглөө говийн нарыг харах хүсэлдээ хөтлөгдөөд шууд л идээ будаа, сүү цагаагаа өргөж, үр хүүхэд, хань нөхрөө даатган гуйдаг бүсгүйчүүдийн сүлд буюу хийморь овоо болох “Мээм овоо” –ны хажууханд байрлах гэр буудалд хонгов. Гэр буудал гэдэг нэр ахдах газар биднийг угтсан. Учир нь бидний өмнө амарсан хүмүүсийн хэрэглэсэн архи, тамхи тэр гэрт нэвт шингэчихсэн, нөмөрч унтах хөнжил, гудас нь олон хиртэй цагаан хэрэглэлтэй, бие засах газарт нь орохоос цэрвэмээр гээд тоочоод байвал асуудал дүүрэн хоног төөрүүлсэн. Улмаар өглөө нь босоод Говийн ноён догшин хутагт Д.Данзанравжаагийн байгуулсан Хамрын хийдээр аяласан аялалдаа ч сэтгэл дундуур байлаа. Ямар түүхтэй, ямар газраар аялаад байгаагаа тайлбарлуулах ч хүнгүй энэ гоё юм аа, тэр сайхан юм аа хэмээн өөрөсдөө газарчлаад л “Шамбалын орон”-оор зугаалсан бидний аялал өндөрлөсөн дөө. Энэ бол ганцхан жишээ. Энэ мэтээр дотоодын аялагчдад аялах зугаалахын хажуугаар амарч тухлах газар даанч алга. Бидэнд аялал ингэж санагдаж байгаа юм чинь манай улсыг зорин ирсэн гадаадын жуулчдад Монгол орноор аялах аялал ямар сэтгэгдэл үлдээх нь ойлгомжтой. Энэ мэт энгийн асуудлыг шийддэггүй байж салбарын дарга нар аялал жуулчлалыг хөгжүүлж, мөнгө олох мөрөөдлөө ярьсаар л суух юм даа.

М.ЭНХБОЛД МАН-ЫН “ТОЛГОЙ” ДЭЭР САНДАЙЛЖ, З.ЭНХБОЛД АН-ЫН “ХӨЛ”-ӨӨС ЗУУРСААР...



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Сүүлдээ иргэд үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг үймээд эхлэхээр өндөр албан тушаалтнуудын цалинг хасаж гэж байгаа юм гэж өөрийгөө хамгаалав. Уг нь бол сайхан л санаа. Гэхдээ хэдэн даргын цалинг бага сага бууруулаа гээд төсөв хэмнэгчид бол сайхан л байна. МАН үнэмлэхүй ялалт байгуулчихаад хийж байгаа ажил нь нэг иймэрхүү. Засгийн газар нь мэргэжлийн бус, дээрээс нь яст мэлхийн хурдтай, юу хийх учраа олохгүй, төв талбайн нэрээр оролдсон маягтай л. “Үүний цаад учир нь М.Энхболд дарга намынхаа нөхдүүдийн “толгой” дээр гарч суусантай холбоотой гэж намынхан нь үзэж байна. “Тэр дараагийн Н.Энхбаяр болж хувирлаа” гэж дүгнэх хүмүүс ч олон байна. Тийм яриа газар

авчихаж. Аргагүй л дээ, МАН-ын дарга М.Энхболд томилгоо тал дээр хэнтэй ч зөвлөлдөхгүй, ганцаараа бие даан шийдэж байгаа сурагтай. Намдаа нойр хоолоо хасан байж зүтгэсэн хэсгийг үл тоож, өөрийн эсвэл халаас зуунтайг сонгож байгаа юм байх. Ерөнхийдөө өөрийнхөө хүмүүсээр төрийг дүүргэж, чирж яваа нөхдүүдээ өндийлгөх гэж зүтгэж байгаа юм уу даа, янз нь. Яамны сайдууд, дэд сайдууд, яам агентлагийн дарга нар гээд олон томилгоо ард түмний дургүйцлийг төрүүлж байгаа. Нэг талаас нь харвал Төв аймгийн Засгийн газар ч юм шиг. Эсвэл уяачдын Засгийн газар ч юм шиг. Нөгөө морь ч юм шиг, аав, ээж ч юм шиг харагдаад байдаг уулын тухай дуу шиг л юм болж байна. МАН ялснаар энэ намынхан биш Төв аймгийнхан болоод уяачдын “нар” л гарав бололтой. Уг нь МАН-ынхан өөрсдийгөө боловсон хүчин сайтай гэж цээжээ дэлддэг. Оргүй биш л үг. Цөөнгүй жил төрийн албанд ажилласан туршлагатай хүмүүс ч дүүрэн бий. Гадаад, дотоодод өндөр боловсрол эзэмшсэн залуучууд ч байгаа. Харамсалтай нь тийм хүмүүст албан тушаал амар олдохгүй байгаа бололтой юм. Тиймдээ ч нам дотроо нэлээд ширүүхэн шүүмжлэл өрнүүлж, залуучууд нь бухимдаж эхэлсэн сурагтай. Арга ч үгүй биз, нам нь ялагдсан дөрвөн жил гадаадад “бүгж” байгаад сонгуулийн өмнө ирж хэдэн төгрөг “шидчихдэг”. Тэгээд ялалт байгуулахаар нь хөрөнгө оруулалтынхаа оронд албан тушаал аваад, зөөлөн сандалд суугаад, дарга сэтэр зүүж байгаа нөхдүүддээ намын жинхэнэ үнэгч гишүүд, зүтгэж ажилласан хүмүүс нь дургүйцэж л таараа шүү дээ. Тэглээ гээд яах вэ, М.Энхболд дарга тэртэй тэргүй бүх эрх мэдлийг гартаа атгачихсан хойно Төв аймгийнхнаа өөд нь татна уу, уяачдаа албан тушаалд “сойно” уу, хамаагүй л хэрэг болж. Харин УИХ, Засгийн газраа аятайхан л “базаасай” билээ.

АН ялагдсан удирдлагуудтайгаа орон нутгийн сонгуульд орох уу

Өнгөрсөн дөрвөн жилд хийж хэрэгжүүлсэн ажил их учраас 2016 оны сонгуульд ялалт байгуулахаар үгүй юм гэхэд хамтарсан Засгийн газар байгуулахаар хэмжээний суудал авна гэж мөрөөдөж байсан АН-ынхан “далаараа тавиулсан”. Энэ ялагдлыг олон хүн янз бүрээр л тайлбарлаж байгаа. Ганц үнэн гэвэл АН навс ялагдсан. Ялагдал энэ намд шинэчлэл хэрэгтэй байгааг ч харууллаа. Гэвч АН-ынхан өнөөдрийг хүртэл ҮЗХ-гоо ч хуралдуулаагүй, намын даргаа ч солиогүй л явна. МАН-ынхан янз бүрийн мэдэгдэл хийхээр нь

...МАН ялснаар энэ намынхан биш Төв аймгийнхан болоод уяачдын “нар” л гарав бололтой. Уг нь МАН-ынхан өөрсдийгөө боловсон хүчин сайтай гэж цээжээ дэлддэг. Оргүй биш л үг. Цөөнгүй жил төрийн албанд ажилласан туршлагатай хүмүүс ч дүүрэн бий. Гадаад, дотоодод өндөр боловсрол эзэмшсэн залуучууд ч байгаа. Харамсалтай нь тийм хүмүүст албан тушаал амар олдохгүй байгаа бололтой юм...

хариуг нь цахим хуудас, сонин сайтаар барьчихаад л сууж байна. Хааяа нэг шаардлага энэ тэр эрх баригчдад хүргүүлээд л, өөр хийсэн юм алга. Угаасаа юу ч хийх юм билээ, тэдний хүч хүрэхээсээ нэгэнт өнгөрсөн. Гагцхүү намынхаа даргыг бушуухан сонгож, томилгоо ажлаа яаравчилмаар юм. Ард түмэн үгийг нь сонсчихдог гайгүй шиг хүнээ дарга болгох биз. Түр зууртаа Д.Эрдэнэбат даргалаад л байж байна. З.Энхболд дарга өөрийгөө сануулсхийн, цахим ертөнцөөр МАН-ын сайд нарыг хөөрхөн “шоглоод” л сууж байгаа шүү дээ. Гэтэл удахгүй орон нутгийн сонгууль болох гээд байдаг. Иргэд МАН-дхэтэрхий ихитгэж, үнэмлэхгүй ялалт байгуулахаар хэмжээнд сонгосныхоо дараа амаа бариад эхэлсэн. Сайд томилгоо үед л МАН хулхиджээ гэдгийг нь харчих шиг боллоо. Сангийн сайд нь гарч ирээд “МАН мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжгүй” гэж шууд мэдэгдсэний дараа шилний цаанаас чихэр долоолгосныг цөөнгүй хүн ойлгосон болов уу. Тийм болохоор АН аятайхан байвал орон нутгийн сонгуульд ялалт байгуулах боломж байна. Гэтэл сонгуулийн өмнө дотоод

асуудлаа шийдэж чадах эсэх нь эргэлзээ төрүүлээр байгаа нь харамсалтай. ҮЗХ-ныхоо хурлын товгыг хэд ч зарлаж, хойшлуулав. Энэ янзаараа УИХ-ын сонгуульд ялагдсан удирдлагуудтайгаа орон нутгийн сонгуульд оролцох юм биш биз дээ. Нэгэнт З.Энхболд харилцаагаа хүлээгээд, ажлаа өгнө гээд хэлчихсэн юм чинь одоо ажлаа шуурхайлмаар юм. Тэгэхгүй бол мань хүн үе үе өөрийгөө сануулаад, иргэдэд намын дарга хэвээрээ ч юм шиг сэтгэгдэл төрүүлээд, АН-ын “хөл”-өөс зуураад байна уу гэмээр. Өөрчлөлтийг хурдан хийвэл зүгээрэн. Ард түмний 45 хувийн итгэлийг дахин хөсөрдүүлэх юм болов уу.

О.Баасанхүү МАХН-ын дарга болбол...

МАН болоод АН-ын дундуур нэг нам гэнэтийн дохилт хийж гарч ирсэн нь МАХН. Одоогийн МАХН-ынхан Х үсгээ ад үзсэн нь Н.Энхбаярт сайхан “зууш” болж, МАХН гэсэн нэрийг авч, өнөөдрийг хүртэл хувьдаа өмчилж яваа. Өнгөрсөн дөрвөн жилд МАХН төрд гол тоглогч байж, эрх баригч АН-ыг хөөрхөн атгаж байлаа. Гэвч энэ удаагийн сонгуулиар навс ялагдаж, ердөө ганц гишүүнтэй үлдсэн. Хэний ч тооцоонд байгаагүй О.Баасанхүү гишүүн Эрдэнэтээс гарч ирснээр Н.Энхбаярыг тоглолтоос хасчихалгүй, “сэлгээ”-нд суулгаж байгаа юм. Ямар ч байсан тэр парламентад суудалтай намын дарга болж чадсан. Түүнийхээ ачаар Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох боломжтой. Гэхдээ энэ талаар ярих эрт байна. Түүний хэргийг цагаатгах нь битгий хэл сайхан баривчлах гэж оролдсон. Яг үүндээ түүнээс МАН-ынхан хүртэл жийрхэж байгаа нь харгадлаа. Харин МАХН-ын нэр хүндийг аварч, Н.Энхбаярыг “сэлгээ”-нд ч болов суулгаж байгаа О.Баасанхүү ойрноос жаахан дээшээ залрахаар шийдсэн сураг байна. Мань хүн Н.Энхбаярыг намын даргын суудлаа надад өг гэж шахсан юм уу даа, янз нь. Өнөөдөртөө Н.Энхбаяр гэдэг хүн хэн ч биш болох дээрээ тулчихаад байна. Өнгөрсөн дөрвөн жилд Солонгост хэвтгээд төрөөр тоглож байсан “том мод” түүнд алга. Ганц барьц нь О.Баасанхүү болчихоод байна. Мөн МАХН гэдэг Н.Энхбаярын нам биш шүү дээ. Энэ чинь олон гишүүн, дэмжигчидтэй улс төрийн нам байлгүй дээ. Тийм болохоор намынхаа нэр төрийг аварсан О.Баасанхүү дарга болж яагаад болохгүй гэж. Н.Энхбаяр гуай О.Баасанхүүд намын даргын суудлаа өгчихөөд, өөрөө Ерөнхийлөгчийн сонгуульд орох боломжоо хайгаад сууж байсан нь дээр ч байж болох юм.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016 оны 8 дугаар сарын 18-ны өдөр

Гэрээний нэр, дугаар: Багануур ХК-д харуул, хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх, СШУ № БНХК 2016-04-01

1. “Багануур” ХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг Багануур ХК-д харуул, хамгаалалтын ажил үйлчилгээ үзүүлэх тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендерийн баримт бичиг /болон нэмэлт хувь/-ийн иж бүрдэл бүрийг нь албан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 100000 /нэг зуун мянган/ төгрөгөөр Худалдаа хөгжлийн банкны 499031495 тоот дансанд тушаан худалдан авах боломжтой.
3. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба тендерийн үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн тендерийн баталгаа хамт ирүүлнэ.
4. Тендерийг 2016 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн 09 цаг 30 минутаас өмнө доорхи хаягаар ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 09 дугаар сарын 19-ны өдрийн 10 цаг 00 минутад нээнэ.

Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр, ажлын цагаар хаяг № 1-ээс худалдан авах ба тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг № 2-оос авч болно.

Хаяг № 1: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, “Багануур” ХК-ийн төлөөлөгчийн байр, Төлөөлөгч Р.Энхбаатар
Утас 70157719, 99098715, 99023137 Факс 70157719
Хаяг № 2: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3 хороо Үйлдвэр хэсэг Багануур ХК-ийн байр 309 тоот өрөө ӨТХ-н инженер Г.Хасбаатар
Утас: 7021-0310 Дотуур утас-1051

ДЭЛХИЙ



САН БЕРНАРДИНОГИЙН 82 МЯНГАН ИРГЭН ГУДАМЖИНД ГАРЛАА

...Сан Франциско хотоос хойш 160 км-т орших бүс нутагт ч энэ сарын 13-ны өдрөөс хойш түймэр дэгдэж, эдүгээг хүртэл 16 хавтгай дөрвөлжин км газрыг хамарч, 175 байшин барилга сүйджээ. Гэвч салхитай бүгчим халуун цаг агаар ойрын өдрүүдэд үргэлжилж, гал түймэр илүү хурдтай илүү их талбайд тархаж байгаа албаныхан анхааруулж байна...

хээрийн түймрийн улмаас гудамжинд гарчээ. Иргэдийн амь насанд аюултай байдал үүссэнтэй холбоотойгоор мужийн захирагч Жерри Браун бүс нутгийн хэмжээнд онц байдал зарласнаа тунхаглалаа. АНУ-ын гамшгийн ажиглалт хийх цахим сестим "InciWeb"-ээр үзүүлснээр гал өчигдөр өглөөний 10 цагийн үед гарчээ. Гал түймрийн цар хүрээ аль хэдийн 36 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарч, 34500 байшин барилга үнсэн товрого болжээ. Сан Бернардино Лос Анжелес хотоос зүүн тийш 100 хүрэхгүй км-т байрладаг байна. Мужийн хэмжээнд онц байдал зарласнаар нутгийн захиргааны бүхий л төрийн

байгууллагын ажилтнууд гал түймрийг унтраах ажиллагаанд дайчлагдахаар болсон аж. Калифорнид таван жилийн турш урьд өмнө нь байгаагүй хэмжээнд халж буйн улмаас гал түймэр удаа дараа гарч, ихээхэн хэмжээний хохирол амсаад байна. Одоо ч гал түймэр дүрэлзэн ассаар байгаа гэнэ. Сан Франциско хотоос хойш 160 км-т орших бүс нутагт ч энэ сарын 13-ны өдрөөс хойш түймэр дэгдэж, эдүгээг хүртэл 16 хавтгай дөрвөлжин км газрыг хамарч, 175 байшин барилга сүйджээ. Гэвч салхитай бүгчим халуун цаг агаар ойрын өдрүүдэд үргэлжилж, гал түймэр илүү хурдтай илүү их талбайд тархаж байгааг

албаныхан анхааруулж байна. АНУ-ын хээрийн түймэртэй тэмцэх албаны хэвлэлийн төлөөлөгч Лин Сиелит "Салхины нөлөөгөөр түймэр маш хурдацтай тархаж байна" хэмээн Би Би Си агентлагт ярьжээ. Түймрийн нурам Лас Вегас, Лос Анжелес хотыг холбох гол замыг ч хамарч, 700 орчим гал сөнөөгч түймрийг унтраахаар ажиллаж байна. Галын шалтгаан одоогоор тодорхойгүй байгаа бөгөөд түймэр Мохавегийн элсэн цөлийг чиглэн асч буй ажээ. Тиймээс Райтвуд болон Феланы цөлийн хотын оршин суугчдыг болзошгүй аюулаас хамгаалах зорилгоор нүүлгэн шилжүүлэх болжээ. Феланы

фермер Шаннон Андерсон Ассошэйтэд пресс агентлагт өгсөн ярилцлагатаа "Энд үнсэн бороо орж байна" хэмээн байгаа юм. Галын шалтгаан хараахан тодорхой болоогүй гэдгийг дээр дурьдсан. Гэхдээ Калифорнийн цагдаагийн газар тус хэрэгт холбогдуулан 40 настай Дамин Пашлик гэгчийг саатуулаад байгаа тухай мэдээлэл барууны сайтуудад гарсан байлаа. Түүнийг өнгөрсөн жилээс хойшхи нийтдээ 17 удаагийн гал түймрийн хэрэгт сэжиглэж буй аж. Харин гурав дахь түймэр Калифорнийн төв хэсэгт асч өнгөрөгч амралтын өдрөөс хойш 6900 акр талбайг хамарч 40 байшин барилга шатжээ.

"Эл Чапо"- гийн хүү хулгайлагдлаа

Мексикийн Пуэрто-Вальярта хотын ресторанаас хулгайлагдсан хүмүүсийн дунд хар тамхины зартай наймаачин Хоакин "Эль Чапо" Гусманы хүү байсан гэж албаны хүмүүс мэдэгдэв. Тэдний мэдээлснээр, "Jalisco New Generation" бүлэглэлийн гишүүд "Sinaloa Cartel" бүлэглэлийн зургаан гишүүнийг хулгайлсан бөгөөд тэдний дунд өдгөө 29 настай Есус Алфредо Гусман байсан байна. Одоогийн байдлаар шоронд хоригдож байгаа Эль Чапо "Sinaloa Cartel" бүлэглэлийг хэдэн жилийн турш толгойлж байсан билээ. Харин хүү Есус Алфредо Гусман тус бүлэглэлийн томоохон гишүүн бөгөөд түүнийг хар тамхины хэргээр АНУ-ын албаны хүмүүс эрэн сурвалжилж байгаа ажээ. Үүнээс гадна их хэмжээний хар тамхи АНУ руу хууль бусаар нэвтрүүлсэн хэргээр тус улс Эль Чапог шилжүүлэх авах хуультай байгаа билээ. Тэрбээр хамгийн чанга дэглэмтэй, өндөр хамгаалалттай шоронгоос 1.6 км урт хонгилоор оргож байсан бөгөөд зургаан сарын дараа буюу өнгөрсөн нэгдүгээр сард дахин баривчлагдсан байна.

Бразилийн далбааг хагас бөхийлгөв

Олон улсын холбөмбөгийн холбооны экс Ерөнхийлөгч Жоао Авеланж энэ сарын 16-ны өдөр Рио де Жанейро хотын эмнэлэгт 100 насандаа таалал төгсчээ. Тэрээр Бразилийн Рио де Жанейро хотоос гаралтай бөгөөд Олон улсын холбөмбөгийн холбооны тэргүүнээр сонгогдсон 1974 онд Европын бус гаралтай анхны хүн болж байв. Үүнээс гадна Олон улсын Олимпын хорооны гишүүнээр 48 жил ажиллажээ. Гэвч Жоао ФИФА-ын тэргүүнээр ажиллаж байхдаа авлигын хэрэгт сэжиглэгдсэнтэй холбогдуулан 2011 онд гишүүнээс огцруулж байсан удаатай. Ямартай ч, түүний гэгээн дурсгалыг хүндэтгэн Рио де Жанейро хотын олимпын хороо Бразилийн төрийн далбааг хагас бөхийлгөхөөр болсон байна.

ОХУ Ираны баазаас Сирид цохилт өгчээ

Б.ДАВАА

Сирид "Лалын улс" болон босогчдын бусад бүлэглэлд ОХУ агаараас цохилт өгөхдөө Ираны агаарын цэргийн хүчний баазыг анх удаагаа ашиглажээ. Тус улсын цэргийнхний хувьд 2014 оны есдүгээр сараас хойш Сирийн хэт даврагчдын эсрэг цохилт өгч эхэлсэн ч, Ираны цэргийн баазыг ашиглаж байгаагүй юм. ОХУ-ын БХЯ-ны мэдэгдсэнээр, Ираны баруун нутгийн Хамадан агаарын цэргийн хүчний баазаас "Туполев-22М3" алсын тусгалтай бөмбөгдөгч онгоц болон "Сухой-34" тактикийн бөмбөгдөгч онгоцоор мягмар гарагт босогчдын байршлуудад агаараас цохилт өгсөн байна.

Сирийн хойд нутгийн Алеппо, зүүн нутгийн Дейр аль-Зур болон баруун хойд нутгийн Идлиб мужид босогчдод агаараас цохилт өгөн сумны таван томоохон агуулах болон бэлтгэл сургуулилын баазыг устгажээ. Мөн босогчдод дэмжлэг үзүүлэхэд ашигладаг байсан хяналтын төвүүдийг устгасан байна. Сирид агаараас цохилт өгөхдөө Оросын арми анх удаагаа Ираны цэргийн баазыг ашигласан нь энэ аж. Оросын албаны хүмүүс тайлбарлахдаа "бөмбөгдөгч онгоцууд Иранаас нисэх нь түлшинд хэмнэлттэй" гэсэн байна.

Турк Ф.Гюлинд ял төлөвлөжээ

Туркид цэргийн эргэлт хийхийг завдсанаас хойш яг нэг сарын хугацааг үдээд байна. Туркийн Засгийн газрын хувьд цэргийн эргэлтийг лалын хэт даврагч бүлэглэлийн удирдагч, шашин судлаач нэрт сэтгэгч Гюлен Фетхуллахыг хөшигний араас удирдсан хэмээн хардаж, түүний орогнож буй АНУ-аас өөрийн улсын талд шилжүүлэн өгөхийг шаардсан. Гэвч АНУ-ын тал одоогийн байдлаар эл асуудалд тодорхой хариулт өгөхөөс татгалзах болсноор хоёр улсын харилцаа улам бүр муудсаар байгаа юм.

Хоёр улсын найрамдалт харилцаанд нөлөөлөхөд хүргэсэн дээрх хэргийг Туркийн цэргийн зарималбантушаалтнууд өдүүлж, төрийн эргэлт хийхийг завдсан ч хотын иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсны улмаас хагас өдрийн дараа бүтэлгүйтлээр төгссөн. Энэ үеэр нийтдээ 240 хүн амь үрэгдсэн бөгөөд тэдний дунд хотын гэм зэмгүй иргэд олноороо багтаж байжээ. Цэргийн



эргэлттэй холбоотойгоор эдүгээг хүртэл 20 гаруй мянган цэргийн алба хаагчид баривчлагдан саатуулагдаж, харин гол удирдагчийг нь Гюлен хэмээн хардаж буй Туркийн эрх мэдэлтнүүд Нэгдсэн улсад удаа дараа шаардлага хүргүүлсээр байгаа тухай албаны эх сурвалж мэдээлж байна. Гэвч сэжигтэн цэргийн эргэлт дэх өөрийн оролцоог эрс үгүйсгэсээр байгаа юм. Тэгвэл Туркийн Прокурорынхон аль хэдийн Фетуллах Гюлинд ял төлөвлөсөн нь ил боллоо. Тус

байгууллагаас мэдээлснээр Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоганы эсрэг боссон Гюлинд бүх насаар нь хорих ял мөн чанга дэглэмтэй хорих ангид 1900 өдөр хоригдох ялыг төлөвлөжээ. Тус улсын "Анадолу" агентлагийн мэдээлснээр прокурорын газрын 2527 хуудас бүхий баримтад Гюлинг террорист ажиллагаа зохион байгуулсан, төрийн эрхийг булаахыг оролдсон, Үндсэн хуулийн зүйл заалтыг үгүй хийхийг оролдсон" гэх мэт үндэслэлээр яллах гэж буй тухай дурьджээ.

Олон үйлдэлт
Ухаалаг чанагч

• Будаа агшаагч • Бялуу жигнэгч • Халуун тогоо • Битүү чанагч

ОНЦЛОХ ХУУДАС

ӨҮЙ ГҮ ӨҮЙ АҮ?



Засаг даргаас ЕРӨНХИЙ САЙД

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

“Монголын мэдээ” сонин “Хэн нь бэ” булан энэ удаагийнхаа дугаарт Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд Жаргалтулгын Эрдэнэбатыг онцолж байна. Дашрамд өгүүлэхэд, дараагийнхаа дугаарт түүний танхимын гишүүдийг танилцуулах болно.

Гэрэл зургийг Г.АРТҮҮЖИН

Дээлийнхээ шинэ дээр төрийн сэнтийд заларсан улстөрч

С.Баяр нэгэнтээ “Яагаа ч үгүй байгтлаа лээддэгддэг ирсэн залуус биш харин шинэ ёс суртахуунтай, бие нь ч нэр төр нь бүтэн шинэ үеийг гаргаж ирэх цаг болсон” хэмээн хэлсэн нь бий. Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайдын тухайд монгол түмнийг тийм хүний эрэлд хатаасан улс төрчийн нэг уг нь. Учир нь түүний нэр хүнд улс төрийн тавцанд аль ч талаараа бүтэн яваа юм, өнөөдрийн тухайд. Хувь хүн талаасаа ч нийгэмд аядуу зөөлөн, ядарч яваа нэгний үгийг бөхийгөөд сонсчих ухаантай нэгэн харагддаг. Хойшид хэрхэн үнэлэгдэх тухайд өөрөөс нь, танхимынх нь нөхдөөс шалтгаална. Алсын аянд ямархан хүлэгтэй мордсоныг нь, хэний хүүтэй ханьсаныг нь цаг хугацаа харуулах нь дамжиггүй. Гагцхүү хонины арьс нөмөрсөн чоностай бага таарасай билээ. Нөгөөтэйгүүр, Ж.Эрдэнэбат улс төрд ороод төдийлөн удаагүй тодруулбал, УИХ-д хоёр дахь удаагаа л сонгогдож буй түшээ. Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч, Засаг даргаар ажилласан найман жилийг улс төрийн албан тушаал гэдгээр нь авч үзвэл өмссөн дээлийнх нь ар тал л дээд хэсгээсээ гандах маяг орж яваагаас элэгдэж хуучрах тухайд яагаа ч үгүй шинээрээ шахам яваа улстөрч. Гэвч тэр дээлийнхээ шинэ дээр олон арван гандсан дээлтэй акалуудыг ардаа орхиж, Монгол Улсын Ерөнхий сайд гэх төрийн өндөр сэнтийд заларч чадсан азгай нөхөр. Тэрбээр богино хугацаанд хэдий ч Сангийн сайдаар ажиллаж, Монгол Улсын төсвийг зангидаж явсан санхүүч. Ж.Эрдэнэбатыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилж тухай асуудал ногоон гэрлээр шийдэгдсэн. Түүн шиг УИХ-ын чуулганы хуралдаанаар нийт гишүүний 97.1 хувийн саналаар дэмжигдэж батлагдсан Ерөнхий сайд хэд билээ дээ. Миний санах нь ганц энэ нөхөр. Тэр бас 41 насандаа монгол төрийн сэнтийд заларсан хамгийн залуу Ерөнхий сайдуудын нэг. Дашрамд сонирхуулахад, хамгийн залуудаа буюу 35 настайдаа Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 1998 онд Монгол Улсын Ерөнхий сайд болж байв. Түүнээс өмнө 1996 онд М.Энхсайхан 41 настайдаа, Ж.Наранцацралт агсан 1998 онд мөн 41-тэйдээ насандаа Монгол Улсын Ерөнхий сайд болж байсан байх юм.

Албан тушаал өвлөөгүй хөдөөгийн багшийн хүү

Өнөө цагт удам дамжсан улстөрч, үе дамжсан дарга нар их болж, Томоохон албан тушаалд насаараа наалдаж, төрийн зөөлөн суудалд тухалсан өвгөн

дарга нар хүүхдүүддээ өвлүүлэх холгүй цаг дор та бид амьдарч буй. Эсвэл яам, тамгын газар, агентлагийг шилж сонгож байгаад залгамжлагчдаа ажиллуулдаг. Тэр бүү хэл, хүүдээ УИХ-ын гишүүний суудлыг худалдаж авч өгч эрхлүүлэх нь бий. Тэгвэл Ж.Эрдэнэбат хэн нэгэн нэр нөлөө бүхий улстөрчийн хүү биш. Түүний аав Сэлэнгэ аймгийн Мандал сум, Хэрх тосгоны уугуул. Тосгоны сургуулийн багш өвгөн. Алдар нь Билээгийн Жаргалтулга. Монголчууд мөрөөрөө нэгэн гэж ярьдаг даа. Удмаараа тийм л хүмүүс. Өвгөн эцэг н.Билээ нь биеэ сайхан авч явдаг, нуруу өндөр, нимгэн цагаан царайтай нэгэн явсан тухай, жаал ноён буюу Баатар ван Наваан-Юндэнгийн дэргэд шадарлаж, бийр янтай өвөртөлсөн бичгийн хүмүүн байсан талаар Минжийн хангайн /Зүүнхараагийнхан/ хууччуул ярьдагддаг. Монголын түүхийн музейд Билээ агсны хөрөг “Монгол өвгөн” нэртэйгээр өнөө хэр хадгалагдаж буйг дуулгахад таагтай байна. Б.Жаргалтулга агсны тухайд ч Хараагийнхны, Хэрх тосгоныхны хайр хүндлэлийг хүлээсэн багш, захирагч байсныг нь ч би гуай ч мэднэ. Цагтаа үндэсний бөхөөр хоорхон барилдчихдаг, аймгийн хурц арслан цолтой бөх явсан нэгэн. Аймгийнхаа наадамд хоёр удаа түрүүлж байсан гэнэлээ. Улсын гарьд Пунцагийн Сүхбат агсны багш гэдгээр нь олон түмэн анддаггүй юм билээ. Өвгөн захирлыг алба хашиж явах үед Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны найман жилийн сургууль дэргэдээ мал аж ахуй, газар тариалангийн туршилтын талбайтай гэдгээрээ БНМАУ-д үлгэр жишээ болж явсан билээ. Харин тэднийх гурван үеэрээ боловсролын салбарт сэтгэл оюунаа зориулсан эгэл жирийн багш нар. Эмэг эх Хандсүрэн нь гэхэд Сэлэнгэ аймгийн анхны багш нарын бөгөөд шинэ цагийн крилл үсгийг багачуудад заасан алдарт сурган хүмүүжүүлэгч. Ерөнхий сайдын ээж Л. Пүрэвдулам гэж сумынхаа зоотехникчээр бүхий л насаараа ажилласан буянтай буурал. Монгол Улсад газар тариалангийн салбар өвдөг сөхөрхөд энэ хүн өөд татахын төлөө зүтгэн газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн “Сүүтэй” компанийг байгуулсан байдаг. Түмэнд хүндлэгдсэн буурал эдүгээ үр ачаа тойруулан жаргаж суугаа.

Байцаагчаас Засаг дарга

Монгол Улсын Ерөнхий сайд Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийг санхүүч мэргэжлээр дүүргэсэн нэгэн. 1997 онд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хянан шалгах хороонд шалгалт өгч тэнцсэнээр түүний Монголын төрд сэтгэл оюун, хөдөлмөр зүтгэлээ зориулахын эхлэл тавигдсан аж. Нөгөөтэйгүүр, түүний хэн

болохыг олж хаж, итгэл хүлээлгэн улс төрд хөтөлсөн хүн нь Сэлэнгэ аймгийн Засаг дарга, УИХ-ын гишүүн асан Р.Нямсүрэн гуай. Тэр утгаараа түүнийг 2000 онд байцаагч хийгээд харайлгаж явахад нь дэргэдээ авч аймгийнхаа санхүү, төсвийг хариуцуулсан нь оносон тухайгаа эдүгээ хуучилж суусан. Аймгийн санхүү албаны даргаар найман жил ажиллах хугацаандаа мэддэг, чаддаг бүхнээ нутгийн зон олондоо харуулж, тэр хэрээр итгэлийг нь олж чадсан учраас түүнийг Залуучуудын холбооны тэргүүнээр баталсан төдийгүй 2008-2012 онд сэлэнгэчүүд санал нэгтгэйгээр Засаг даргаараа сонгож, хувь заяагаа даатгажээ. Ж.Эрдэнэбатыг Засаг даргаар ажилласан он жилүүдэд Сэлэнгэ аймаг улсад ажил үйлсээрээ жилдараалан шалгараад зогсохгүй “Атрын III аян”-ыг амжилттай хэрэгжүүлсэн тул Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан Сүхбаатарын одонгоор шагнасан байдаг. Эдүгээ Монгол Улсын хэмжээнд Сүхбаатарын одонтой аймаг хэд билээ дээ. Миний мэдэхийн ганцхан Сэлэнгэ шүү дээ. Үнэндээ түүнийг ажил хүлээж авахад сэлэнгэчүүд эргэлтийн талбайнхаа дөнгөж 30 хувьд нь үр тариалдаг байсан бол дөрвөн жилийн дараа буюу УИХ-д сэлэнгэчүүдээ төлөөлөн суухаар мордоход дээрх үзүүлэлт 100 хувьд хүрсэн байх жишээтэй. Засаг даргаар ажилласан хугацаанд сэлэнгэчүүд халтар нүүрээ зад угаасан хүүхэд шиг л аймгийнхаа төвийг өөд татаж хөгжүүлсэн гэж хэлж болно. Эдүгээ түүнийг Монгол Улсаа хөгжүүлэх асар хүнд итгэл найдвар хүлээж буй.

Ерөнхий сайдын багийнх нь нэр Эдка

Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат дөрвөн хүүхэдтэй айлын хөвгүүдийн том нь. Түүнийг хүүхэд байхын лаядуу зөөлөн зантай, чих зөөлөнтэй, эмэгтэй хүүхэд адил ар гэрээ авч явдаг хүү байсан талаар авга эгч Б.Мөнгөнцэцэг нь нэгэнтээ хуучилсан. Ерөнхий сайдын багын нэр нь Эдка. Эдка дээрээ нэг эгчтэй, доороо хоёр эрэгтэй дүүтэй. Тэднийхэн бүгдээрээ эцэг өвгөдийнхөө нутагт аж төрж буй. Том эгч Ж.Соёл-Эрдэнэ нь Мандал сумынхаа нэгдсэн эмнэлэгт уламжлалын эмчээр ажилладаг бол дүү Ж.Эрдэнэцогт нь сумынхаа ЗДТГ-т Нийгмийн даатгалын тасгийн дарга, дүү Ж.Эрдэнэтөгс нь ээжийнхээ байгуулсан “Сүүт” компанийг авч яваа. Монгол Улсын Ерөнхий сайдын гэргийг Тунгалаг гэдэг. Залуус дээд сургуулийн нэг ангийн оюутнууд гэхээр зах зээлийн эдийн засагч мэргэжилтэй байж таарах нь. Ханиа дагаад Мандал суманд ажиллаж, үнээ тугалтай ч ноцолдож үзсэн ажилсаг бүсгүй бий. Эдүгээ санхүүгийн

байгууллагад алба хашиж яваа. Тэднийх ам бүл тавуул. Том охин нь “Мон Турк” дунд сургуульд, дунд охин нь “Хобби” дунд сургуульд, бага хүү нь цэцэрлэгт явдаг.

Ерөнхий сайд дөрвөн компанид хувь эзэмшиж, нийт 99 саяын орлоготой

АТГ-т өнгөрсөн онд мэдүүлсэн төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгээс Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын мэдүүлгийг сонирхож үзлээ. Тэрээр нийт 99 сая төгрөгийн орлоготой гэж мэдүүлсэн байна. Гурван орон сууцтай бөгөөд дөрвөн компанид хувь эзэмшдэгээс нэг нь 100 хувь Ерөнхий сайдынх юм байна. “Toyota Land cruiser 105”-1, “Toyota highlander”-1, “Lexus-570”-1 гэсэн гурван автомашинтай, нийт 116 сая төгрөгтэй тэнцэх малтай юм байна.

Түүний ажлын туршлага нь:

- 1996-1997 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Сүүтэй” ХХКомпанид нягтлан бодогч,
- 1997-2000 онд Сэлэнгэ аймгийн Хянан шалгах хороонд байцаагч,
- 2000-2004 онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга,
- 2004-2005 онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч,
- 2005-2008 онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар ажиллаж байгаад 2008-2012 онд Сэлэнгэ аймгийн Засаг даргаар томилогдон ажилласан.
- Ж.Эрдэнэбат 2012 оны Улсын Их Хурлын зургаа дахь удаагийн сонгуулиар Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Улмаар 2014 оны арванхоёрдугаар сарын 9-ний өдрөөс Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар томилогдон ажиллаж байжээ.

Боловсролын байдал нь:

- 1981-1991 онд Сэлэнгэ аймгийн Мандал сумын 10 жилийн дунд сургууль,
- 1992-1995 онд Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургууль,
- 1997-1998 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт,
- 2002-2004 онд Удирдлагын академи,
- 2003-2005 онд Хөдөө аж ахуйн их сургууль тус тус төгссөн. Эдийн засагч мэргэжилтэй. Эдийн засгийн ухааны магистр, англи

МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатарын дагуул хот Налайх дүүргийн баруун хойдох дэнж дээр дэлхийн жишигт хүрсэн оюуны нэгэн уурхай үүдээ нээгээд гурван жилийн хугацаа өнгөрчээ. Аль Богд хаант засгийн үеэс Нийслэл хүрээний дагуул гацаа маягтай жаахан алт үнэртсэн, нэгэн луухааны ухсанаар хар алтны уурхай олдож, улмаар 1921 оны хувьсгалаас хойш ардын засгийн жилүүдэд Монгол Улсын анхны уурхайн шав тавьсан түүхт газар бол Налайх юм. Энэхүү Налайхын их уурхай Монгол Улсын нүүрсний гол том төв болсоор ирсэн. Налайх гацаа өргөжин Налайх хот боллоо хөгжжээ. 1990 оны үеэс их уурхай хаагдаж, доvon дээр нь хувийн олон уурхайн “оорхой” бий болж, өнөөдрийг хүртэл нийслэлийн гэр хорооллынхны галыг залгуулсаар байна. Харин Налайхыг дахиад дэлхийд нэрлүүлэх сургууль баруун хойд дэнж дээр нь бий болсныг бид газар дээр нь үзээд ирлээ.



Гэрэл зурагийг Г.АРИУУЖИНИ

ДЭЛХИЙ РҮҮ ХАРСАН ЦОНХ ДЭРГЭД МИНЬ БАЙНА

ГЕРМАН МЭДЛЭГ-МОНГОЛ УХААН

Монгол Германы Ашигт малтмал, Технологийн их сургууль буюу МГТИС нь хоёр орны Засгийн газрын хамтын ажиллагааны үрээр 2013 онд байгуулагдсан. Тус сургууль төрийн өмчийн анхны сургууль гэдгээрээ бас онцлогтой. Уг нь энэ сургуулийн анхны гэрээ хэлцлийг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ХБНГУ-д төрийн айлчлал хийх үеэрээ тус улсын канцлер Ангела Меркельтэй уулзахдаа хийсэн юм. Мөн энэ айлчлалын хүрээнд уул уурхайн гол төв болсон Дюссельдорф хотод айлчилж, уул уурхайн үйлдвэртэй танилцан Монголын Тавантолгойн коксжих нүүрсээ ч германд нийлүүлэх асуудлыг ярьж байсныг бивээр сурвалжилсан тул дэлхий рүү харсан цонхтой МГТИС-ийн тулгын чулуут цаасан дээрээс эхлээд цасан дээр мөрөө гаргасныг нь ийнхүү мэднэ гэхэд дэгсдэхгүй ээ. Герман мэдлэг, боловсрол гэхээр дэлхийн мэдлэг оюуны чанар бас мэдрэгдэнэ. Германы уул уурхай гэхээр дэлхийн технологийн чанар илүүтэй мэдэгдэнэ. МГТИС нь Монгол Улсын дээд боловсролын шинэчлэлийн загвар сургууль гэхэд хэлсдэхгүй.

Тиймээс тус сургуульд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, ХБНГУ-ын ерөнхийлөгч Иоахим Гаук, УИХ-ын дарга З.Энхболд, БСШУ-ны сайд Л.Гантөмөр нар зочлон багш, оюутнуудтай уулзжээ. МГТИС нь аж үйлдвэр болон нийгмийн хэрэгцээнд үндэслэн Азийн бүс нутаг дахь “хэрэглэлийн судалгаа”-ны тэргүүлэх хүрээлэн болохыг зорьж байна гэж тус сургуулийн захирал Н.Дорждэрэм ярьсан. Тус сургуульд өнөөдөр 100 гаруй оюутан суралцаж байгаа бөгөөд тэд герман стандартын сургалтын хөтөлбөрт хамрагдаж байгаа. Багш нар нь АНУ, ХБНГУ-аас ирсэн туршлагатай сурган хүмүүжүүлэгчид олонх нь, мөн Монголын залуу шилдэг боловсон хүчнүүд ч өндөр шалгуур, үзүүлэлтээр өрсөлдөн ажиллаж буйг захирал онцолсон.

МГТИС-ийн захирал, доктор, профессор Нямжавын Дорждэрэм 2014 оны долоодугаар сараас захирлаар ажиллаж байна. Тэрбээр МУИС-ийн физикийн ангийг бакалавраар төгсөн багшилж байгаад АНУ-ын Пурдьогийн их сургуульд 2004 онд докторын зэрэг хамгаалжээ. Мөн АНУ-ын Ютагийн их сургууль, Чикагогийн Лойлагийн их сургууль, Филадельфийн ШУИС-д тус тус багшилж байсан манай шилдэг залуу багш нарын нэг

юм. Тэр сургуулийнхаа тухай “МГТИС-д сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн бүх талуудад ашигтай гурвалсан холбоог бий болгож байна. Герман улс энэ тал дээр туршлагатай, дэлхийд алдартай бөгөөд үүнийг монголдоо хэрэгжүүлэх, илүү өндөр амжилтад хүрэх нь бидний зорилго юм” гэсэн ганцхан өгүүлбэрээр ончтой, товчхон тодорхойлов. Сургуульд амжилттай суралцаж төгссөнөөр Герман, Монгол Улсын хавсарсан дипломтой болно.

Багш, мэргэжилтнүүд нь Европ, АНУ, Япон, Солонгос, Канад, Монгол улсын шилдэг боловсрол эзэмшжээ. Энд чадварлаг багш, оюутан баг болж суралцсанаар дэлхийн шилдэг сургалтын орчныг бий болгосон нь бас харагдлаа. Оюутан суралцахдаа юуны

...Био дизелийн багийнхан сургуулиасаа зохион байгуулсан оюутны анхдугаар симпозиумд идэвхитэй оролцож МУИС, ШУТИС болон Монгол-Японы хамтарсан Коосений технологийн дээд сургуулийн төгсөх ангийн оюутнуудтай өрсөлдөн илтгэл тавьж, био түлш гарган авах технологийн туршилтаараа уралдсан аж...

урьд судалгааны арга барил эзэмшдэг. Сургуульд амжилттай суралцаж төгссөнөөр Герман, Монгол Улсын хавсарсан дипломтой болно. Гадаад улс оронд дахин суралцах шаардлагагүй бөгөөд шууд дэлхийн хаана ч очиж ажиллах чадвар, эрх зүйн боломжтой. МГТИС-ийн багш оюутнууд бие биеийнхээ саналыг чөлөөтэй солилцон, онолын мэдлэгээ судалгаа, сургалтын арга барилтай хослуулж байна. Тиймээс тус сургуулийн лаборатори нь дэлхийн стандартад нийцсэн, яриангүй герман технологи үнэртсэн газар байх аж. Бас нэг онцлогийг дурьдвал, тус сургуулийн англи хэлний багш Линдон Беххари өөрийн сонирхол, санаачилгаар ургамлын тосноос “Био дизель түлш” гарган авах төслийг



сэдэж, үүнд бэлтгэл болон бакалаврын хөтөлбөрийн 11 оюутан сайн дураараа нэгдэн лабораторийн туршилт хийсэн байна.

Энэ туршилт нь маш амжилттай явагдаж байгаа бөгөөд тэд гаргаж авсан түлшнийхээ чанарыг мэргэжлийн байгууллагаар шалгуулж баталгаажуулсны дараа сургуулийнхаа бага оврын автобусанд ашиглахаар тооцжээ. Энэ түлш нь хаягдал ургамлын тосыг ашиглан гаргаж байгаа учраас байгаль хор нөлөөгүй жинхэнэ “ЭКОТҮЛШ” болж байгаа юм. Био дизелийн багийнхан сургуулиасаа зохион байгуулсан оюутны анхдугаар симпозиумд идэвхитэй оролцож МУИС, ШУТИС болон Монгол-Японы хамтарсан Коосений технологийн дээд сургуулийн төгсөх ангийн оюутнуудтай өрсөлдөн илтгэл тавьж, био түлш гарган авах технологийн туршилтаараа уралдсан аж. Туршилт нь ч сонирхол татахаар юм. Оюутан Б.Намууны ярьснаар хоёр литр ургамлын тосноос 1.8 литр буюу /1800 миллилитр/ био түлш гарган авчээ. Тэдний энэ удаагийн төсөл амжилттай болбол дараагийн удаа хүлэмж байгуулан үнэрт ургамлуудыг тариалж саван гаргаж авах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа гэж ярилаа. МГТИС-ийн сургалт англи хэлээр явагддаг. Уг нь герман хэлээр сургалт явуулах боломжтой ч англи хэлийг голлож байна. Одоо сурч буй оюутнууд англи хэлийг сонгон суралцдаг аж. Англи хэл сайн эзэмшсэн бол герман хэлийг сонгож болно. Ер нь төгсөхдөө англи, герман хос хэлтэй төгсөх аж. Тус сургууль нь одоогоор уул уурайн боловсруулах инженер, механик инженер, хүрээлэн

буй орчны инженер гэсэн бакалаврын үндсэн гурван хөтөлбөрөөр сургалт явуулж байна.

Эдгээр мэргэжлүүд нь тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 80 орчим аж ахуй нэгжүүдээс санал асуулга авсны үндсэн дээр гаргаж ирсэн мэргэжлүүд учраас төгсөгчид нь ажлын байр хайх шаардлагагүй гэсэн үг. Өөрөөр хэлбэл салбартаа хамгийн эрэлттэй байгаа мэргэжлүүдээр сургаж байгаа юм. МГТИС нь энэ хичээлийн жилээс магистрын хөтөлбөрөө эхлүүлэх юм байна. Түүнчлэн тус сургуулийн оюутнууд сурлагынхаа амжилтаас хамааран 3, 4 дүгээр ангидаа 1-2 улирал ХБНГУ-ын Фрайбергийн ТИС, Ахений ТИС, Бохумын хэрэглээний Шинжлэх ухааны их сургуульд оюутан солилцоогоор суралцах боломжтой. Хамтран ажиллагч эдгээр сургуулиас багш нар ирж ажиллаж байгаа гэдгийг ч сургуулийн захирал хэлсэн.

АНХНЫ ХОТХОНТОЙ СУРГУУЛЬ

Монголын анхны хотхонтой сургууль нь МГТИС юм. Эндхийн гадаад багш, оюутнууд нь нэгдсэн байранд амьдарч байна.

Оюутны байрны багш Г.Дамдин:

- Манай байранд 59 оюутан бий. Дарханы ес, Эрдэнэтийн хоёр, Хөвсгөлийн нэг, үлдсэн нь Улаанбаатарынх. 14 охин, 45 хөвгүүн байгаа. Оюутнууд хичээлийн таван өдөртөө байрандаа байнга амьдардаг. Харин хагас бүтэн сайн буюу амралтын өдөр ойр гэртэй нь хариад ирдэг. Нэг тасагт

гурвуулаа байдаг. Өрөөндөө тухал тогооны хэрэгсэл, ая гурвал бүрэн хангагдсан гэж яриар.

Тус оюутны байрны 206 дугаар тасагт оров. Энд оюутан Б.Намуун, Э.Уянга, О.Жаргалмаа нар хичээлийн эхний хагас цагаа дуусгаад үдийн завсарлага авч, унд, хоолоо хийхээр эзэж байлаа. Охид англи хэл сайн сурч байгаа гэв. Б.Намуун сургуулийнхаа био түлш гарган авах багт багтан судалгаа хийж байгаа юм байна. 113 дугаар тасагт гурван хөвгүүн шатар тоглож байснаа биднийг ороход хотынх, дэвтрээ цэгцлэхээр ухасхийв. Хөвгүүдийг Г.Балжинням, Г.Билгүүн, Э.Золбоо гэнэ. Гурвуулаа Улаанбаатар хотынх. 119 дүгээр өрөө их сонирхолтой, эрхгүй анхаарал татав. Энд оюутан Ж.Эрдэнэсайхан хообийгоороо загас гэжээх том аквариумаа тавьчихсан нь содон агаад сонин. Яг л гэртээ байгаа юм шиг. Түүний загасны шилэн савайд гурван төрлийн 30 гаруй загас хөвөн ээлнэ. Ж.Эрдэнэсайхан загас сонирхоодхоёржилболжбайгаа ч чөлөөт цагаараа загастайгаа ярьж, тоглож, амрайт алжаалаа тайлдаг байна. Тэр Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийнх. Гэртээ, оюутны байрандаа загас үржүүлж, тэжээдэг боловч бас Туул гол болон эх орныхоо нуур цөөрмөөс загас барих хообийтой гэдгээ ярилаа. Оюутнууд жилд долоон сая төгрөгийн сургалтын төлбөр төлж суралцдаг байна. Дээрх оюутнууд өдөрт 09-12 цаг, 14-16 цагийн хооронд хичээлтэй. Математик, хими, физик, байгалийн шинжлэх ухаан, компьютерын үндсэн хичээлд суралцдаг. Мөн оюутнууд мэргэжлээ эзэмших өөрийн ур чадвартаа тохирсон арга замыг олоход багш нар нь их тус дэм болдог гэж байв. МГТИС-ийн багш нар үйлдвэртэй танилцах аялал хийх, олон салбарын төлөөлөлтэй уулзалт яришлага зохион байгуулах зэргээр оюутнуудаа дэмжин ажилладаг гэж оюутнууд яриар. Оюутнууд жилд долоон сая төгрөгийн сургалтын төлбөр төлж суралцаж байна. Ингэхдээ оюутны байранд байнга байрлаж, хичээлийн бүх хэрэгсэл, лаборатори, номын санд үнэгүй сууж, сургалт, дадлагын хувцсаар ч бүрэн хангагддаг байна.

“ХААЛГА НЭЭЛТЭЙ”

Тус сургуулийн олон нийттэй харилцах албаны ахлах мэргэжилтэн, сэтгүүлч Н.Чулуунцэцэг бидэнд сургуулиа танилцуулсан. Дэлхийн сургуулиуд бол “Хаалга нээлттэй” гэж ярьдаг, үнэхээр ч хаалга нь үргэлж нээлттэй байдаг. Тиймээс ч дэлхийн

том сургуулиуд өөрийн бүхэл бүтэн хотхонтой байх нь элбэг. Оюутан, багш нар сургуулиасаа гарахгүйгээр дэлхийн алхаатай хөл нийлдэг. Сургуулиасаа гарахгүйгээр хоол, унд, ном сурахаараа хангагддаг. Хамгийн ая тохьтой орчинд суралцдаг. Энэ бүхнийг МГТИС-аас харж болно. МГТИС нь одоогоор 100 гаруй оюутантай ч ирээдүйдээ 600-700 оюутан суралцах боломжтой.

МГТИС нь одоогоор 100 гаруй оюутантай ч ирээдүйдээ 600-700 оюутан суралцах боломжтой. Тус сургууль хот, хөдөөгийн сурагчдад боломж олгох үүднээс элсэлтийн шалгалтаа хавар, намар, өвлийн улиралд өргөнөөр зохион байгуулдаг. Энэ намрын шалгалтаа 8 дугаар сарын 19-нд сургуулийнхаа хотхонд зохион байгуулах юм байна. Үндсэн шалгалт нь англи хэл, байгалийн ухааны хичээлээр авна. ЭЕШ-ын 500 онооноос дээш оноотой сурагч шалгалт өгөх боломжтой. Сүүлийн үед АНУ, ХБНГУ-д суралцаж буй оюутнууд монголын МГТИС-д шилжин суралцах санал тавих болсон нь Монгол Улсын төрийн өмчит, отгон сургуулийн үнэлэмж ямар байгааг харуулж байгаа нэг жишээ юм. Ер нь ч МГТИС-т монголоор зогсохгүй хөрш ОХУ, БНХАУ, Азийн орнууд, Европ, Америкаас ч оюутан сургаж боломжтой нь бидний сургуультай танилцах аялалын үеэр харгадлаа. Тус сургуулийн номын сангаар орсноо хэлэхгүй бол болохгүй нь.

Номын санч Б.Бадамцэцэг: “Манай номын сан 4500 орчим номтой. Инхэнхьянгли, герман хэлээр нарийн мэргэжлийн ном байгаа. Үүний 1000 гаруй нь германы мэргэжлийн ном байв. Манайтай хамтран ажилладаг 205 жилийн туршлагатай Фрайбергийн ТИС, Ахений ТИС, Бохумийн хүрээлэнгээс ирүүлсэн хандивын ном ихэнх нь. Бид цахим сүлжээ, интернэтээр дэлхийн шилдэг номын сантай холбогдсон” гэж танилцуулав. Тус номын санд бивээр яруу найрагчийн хувиар “Хаан судар”, “Тар утас чинь болье” номуудаа бэлэглэлээ. Номын санч маань зохиолчидтой уулзах уулзалт хиймээр байна гэв. Үүнийг сургуулийн захирал Н.Дорждэрэм дуу нийлэн дэмжсэн. Удахгүй бид зохиолчидтой хийх уулзалтаар дахин уулзах ерөөл тавьсан. Дэлхий рүү харах цонх дэргэд минь байна. Тэр бол Налайх дүүргийн хоёрдугаар хороонд байрлах Монгол Герман улсын хамтарсан төрийн өмчит МГТИС юм. Эндхийн “Хаалга үргэлж нээлттэй”.

Сурвалжилсан: МОНЦАМЭ агентлагийн сурвалжлагч Ж.БАТСАЙХАН

ШУУРХАЙ МЭДЭЭ

П.ЛХАГВАСҮРЭН: СУРГАЛТЫН ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛД 3500 ОЮУТАН ХАМРАГДДАГ

Н.БАТЗАЯА

Жил бүр сургалтын төрийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй, хагас болон бүтэн өнчин хүүхдүүдэд оюутны сургалтын төлбөрийн зээл олгодог. Энэ талаар сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэнгээс зарим зүйлийг тодрууллаа.

-Сургалтын төрийн сангаас оюутнууд зээл авч, их, дээд сургуульд элсэн ордог шүү дээ. Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлийн талаар мэдээлэл өгөхгүй юу. Энэ зээлд хэрхэн хамрагдах вэ?

-Манай байгууллагаас олгодог сургалтын хөнгөлөлттэй зээлд тодорхой нөхцөл, шаардлагыг хангасан оюутнуудад хамрагддаг. Уг зээлд хагас өнчин, малчин өрхийн, амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагч хамрагдах боломжтой. Мөн гэрээт цэргийн албыг хоёр жилээс доошгүй хугацаанд хаасан суралцагч хамрагдана.

-Хөнгөлөлттэй зээлд хамрагдахыг хүссэн олон оюутнууд байгаа байх. Яаж хамрагдах вэ. Ямар материал бүрдүүлэх шаардлагатай вэ?

-Хөнгөлөлттэй зээлд хамрагдахыг хүссэн оюутнууд материаллаа өөрийн орох гэж буй сургуульдаа бүрдүүлж өгнө. Үүний дараа тухайн сургууль нэгдсэн журмаар манай байгууллагад оюутнуудын материалыг явуулдаг юм. Бүрдүүлэх материалын хувьд өргөдөл, суралцагчийн иргэний үнэмлэхний хуулбар, бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар хэрэгтэй. Мөн Боловсролын үнэлгээний төвийн батламж, үргэлжлүүлэн суралцагчийн дунгийн тодорхойлолт, эцэг, эхийн аль нэг нь нас барсныг гэрчлэх бичиг баримтын хуулбар, малчин өрх болохыг нотлох сум, дүүргийн Засаг даргаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт шаардлагатай. Хэрвээ гэрээт цэргийн алба хаасан бол түүнийг тодорхойлох харьяа аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас баталгаажуулсан албан ёсны бичиг баримт хэрэг болно. Эдгээр материалуудыг бүрдүүлж, сургуульдаа өгснөөр тэтгэлэгт хамрагдах боломжтой.

-Зээлийн эргэн төлөлтийг нь сонирхож болох

уу. Ер нь зээл тусламжид хамрагдсан оюутнууд сургалтын төлбөрөө хэдийд нь төлж дуусгах вэ?

-Хоёр талт гэрээний дагуу зохих журмаар заасан хугацаанд нь төлж барагдуулах ёстой байдаг. Зээлийн хэмжээ нь их, дээд сургууль, коллеж зэргээс шалтгаалан өөр өөр олгогддог. Тодорхой мөнгөн дунгийн хязгаарлалт байхгүй. Зээлээ гэрээний дагуу заасан хугацаанд нь төлж барагдуулах ёстой. Сургуулиа төгсөөд зээлээ барагдуулаагүй тохиолдолд их сургуулийн мэргэжлийн диплом олгодоггүй.

-Сургалтын төрийн сангаас буцалтгүй тусламж олгодог. Энэ тусламжийг ямар оюутнуудад олгодог вэ?

-Оюутны сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжийг бүтэн өнчин бакалаврын зэргийн суралцагч, хөгжлийн бэрхшээлтэй, эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн суралцагчдад олгодог. Гэхдээ хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн суралцагч гэдгийг зөв ойлгох хэрэгтэй. Зөвхөн гэр бүлийн гишүүний нэг нь хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд олгоно. Хүмүүс хамаатны хүн маань хөдөлмөрийн чадвараа алдсан, төлбөрийн буцалтгүй тусламжид хамрагдах гэж ирдэг. Энэ бол буруу. Бат гэдэг айлынх дөрвөн

гишүүнтэй байлаа гэж бодоход тэр гишүүдийн хэн нэг нь хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд л энэ тусламжийг авах боломжтой.

-Буцалтгүй тусламжид хамрагдах боломжтой ч хаана хандах, ямар материал бүрдүүлэхээ мэдэхгүй олон оюутан байгаа байх. Бүрдүүлэх материалын талаар мэдээлэл өгөхгүй юу?

-Суралцагчийн өргөдөл, бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар, Боловсролын үнэлгээний төвийн батламж, БСШУЯ-ны суралцах эрхийн бичиг /томиллолт/, үргэлжлүүлэн суралцагчийн дунгийн тодорхойлолт, эцэг эх, асран хамгаалагчийн болон суралцагчийн иргэний үнэмлэхний хуулбар, эрх бүхий этгээдийн баталгаажуулсан холбогдох баримт бичиг, тодорхойлолтыг авч ирэхэд болно. Буцалтгүй тусламжийн нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд эдгээр материалыг бүрдүүлэхэд болно.

-Жилд хэцээн оюутан сургалтын төрийн сангаас зээл авдаг юм бэ?

-Манай байгууллага 1993 оноос хойш өдөө 23 жил үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ хугацаанд олон мянган оюутан залуусыг сургалтын төрийн сангийн зээлд хамруулж, гадаад, дотоодод мэргэжил боловсрол эзэмшихэд нь тусалсан. Ер нь жил бүр 3500 оюутан сургалтын төрийн сангийн зээлд хамрагддаг.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

БАЯНХОШУУНЫ ЗАМД ХОЁР ХҮҮХДИЙГ МӨРГӨЖ, ГЭМТЭЭЖЭЭ

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газар энэ сарын 16-нд нийт 280 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 193 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй долоон гомдол мэдээлэл бүртгэгдэж, найман хүн хүнд, хөнгөн гэмтжээ. Түүнчлэн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн ослд холбогдсон жолооч нэг, явган зорчигч нэг, зам тээврийн ослд сургуулийн насны нэг хүүхэд өртсөн байна. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн нутаг Баянхошууны зам, Засварын буудлын замд Асепт маркийн авто машины жолооч Ч нь явган зорчигч долоон настай эрэгтэй Б нарын хоёр хүүхдийг мөргөж, гэмтээсэн байна. Тиймээс Замын цагдаагийн газраас бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байхыг анхаарууллаа.

Орхон голыг бохирдуулсан компаниудын тусгай зөвшөөрлийг цуцлахыг сануулжээ

Орхон гол 2, 3-хан жилийн өмнө алт олборлогч компаниудын буруутай үйл ажиллагаанаас болж улаанаар эргэж байсан. Энэ түүх дахиад давтагдаа. Тэгвэл Орхон голын бохирдлыг БОАЖЯ, УУЯ, МХЕГ болон Архангай аймгийн холбогдох албаныхан энэ сарын 6-8-ны өдрүүдэд шалгаад иржээ. Мөн Архангай аймгийн Цэнхэр суманд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын ажилтай ч танилцсан байна. Орхон гол ийн бохирдсон нь Цэнхэр сумын нутагт алт олборлодог “Монгол газар”, “БМНС”, “Голден хаммер”, “Батбродерс”, “Эм Жэй Эйч” зэрэг алт олборлогч компаниудын буруутай үйл ажиллагаанаас болсон юм

байна. Алт олборлогч эдгээр компаниудын ашиглалтын талбайгаас урссан бохир ус Орхон голд цутгадаг Өлзийт тээл, Харгуйт Шийрт зэрэг жижиг голыг бохирдуулсан ажээ. Ингэснээр Орхон гол хэдэн жилийн өмнөхтэй адил шавраар урсч байна. Тиймээс Орхон голд бохир ус хаяж буй зөрчлөө долоо хоногийн хугацаанд арилгах, голын бохирдлыг бууруулах үүргийг тухайн компанийн удирдлагуудад өгчээ. Хэрэв шаардлагыг биелүүлэхгүй бол тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүртэл арга хэмжээ авах юм байна. Мөн Орхон голын бохирдлыг тогтоохоор голын уснаас дээж авсан бөгөөд шинжилгээний харну ирэх даваа гарагт гарах ажээ.

PHOTO NEWS

Залуу монгол судлаачдын зуны сургуулийг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг билээ. Уг арга хэлжээнд оролцогчдыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын П.Цагаан Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд өчигдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад ОХУ, Герман, Швейцарь, Чех, Унгар, Итали, Финланд, БНХАУ, Япон, Австрали, АНУ зэрэг 12 орны 18 их сургууль, судалгааны төвийн 30 гаруй залуу судлаач, оюутан оролцсон.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Д.Мөнхтөр: Улаанбаатар төмөр зам компанийг 1.8 тэрбум төгрөгөөр торгоно

ШӨХТГ-ийн дарга Д.Мөнхтөр Улаанбаатар төмөр зам, Түргэн тусламжийн 103 төвд хийсэн хяналт шалгалтын талаар сэтгүүлчдэд өчигдөр мэдээлэл хийлээ. Тус газарт “Богд төмөр”, “Ерөө гол” компаниуд Улаанбаатар төмөр зам компани тарифаа нэмж байна гэх гомдол гаргасан байна. Гомдлын дагуу шалгахад, Улаанбаатар төмөр зам компанийн дарга 2016 оны зургадугаар сарын 20-нд “Тарифын нэгдүгээр мөрдлөгт өөрчлөлт оруулах тухай” А/196 тоот тушаал гаргаж, воганы хоосон гүйлтийн тарифыг нэмэгдүүлж, 2016 оны долдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэх шийдвэр гаргасан байсан илэрчээ. Иймд тус компанийн өнгөрсөн оны нийт орлогын гурван хувьтай тэнцэх хэмжээний буюу 1.8 тэрбум төгрөгөөр торгохоор болсон тухай мэдэгдсэн юм.

Энэ тухай ШӨХТГ-ийн дарга Д.Мөнхтөр “Манай байгууллагын хурлаар Улаанбаатар төмөр зам компани зүй ёсны монопол байдалтай аж ахуйн нэгж болох нь тогтоогдсон. Монопол буюу давамгайл байдалтай аж ахуйн нэгжүүд үнэ тарифын өөрчлөлт оруулах бол заавал манай байгууллагаас зөвшөөрөл авах ёстой байдаг. Гэтэл тус компани зөвшөөрөл авалгүйгээр тарифаа нэмсэн. Тиймээс 2015 оны нийт орлогын гурван хувь буюу 1.8 тэрбум төгрөгөөр торгоно. Бид Улаанбаатар төмөр зам компанид торгуулийн мэдэгдэх хуудсыг өчигдөр явуулсан” гэв. Мөн энэ үеэр түргэн тусламжийн 103 төвд хийсэн шалгалтын дүнг мэдэгдсэн юм. Шалгалтын явцад түргэний машинд GPS байдаггүй болох нь илэрчээ. Түүнээс болж машиннууд хаана явж байгаа нь мэдэгддэггүй бөгөөд хэрэглэгчдэд хүлээгдэл үүсэх, ирсэн дуудлагад хүрч ажиллаж чадахгүй байх зэрэг зөрчил илэрдэг байна.

Засаг даргатайгаа нийлж, баавгай агнасан этгээдүүдийг цагаатгалаа

Баян-Өлгий аймгийн Алтай сумын тусгай хамгаалалттай “Ёлт” хэмээх газарт бүлэглэн хүрэн баавгай агнасан хэрэг гарчээ. Баавгай агнасан хэргийг тус сумын байгаль хамгаалагч Б, тусгай хамгаалалттай газрын улсын байцаагч С, Алтай сумын гуравдугаар багийн Засаг дарга Ш болон тус сумын иргэн М, С, Д нар бүлэглэн үйлдсэн байна. Тэгвэл Баян-Өлгий аймгийн цагдаагийн байгууллагаас тус хэргийн мөрдөн байцаалтыг дуусгаж, хавтас хэргийн прокурор шилжүүлжээ. Гэвч аймгийн прокурор хянаад “Хүрэн баавгайг агнасан нь тогтоогдоогүй, сэжигтнүүд рүү баавгай дайрсан тул аргагүй хамгаалалт хийж, буудсан” гэсэн шийдвэр гаргаж, хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Тухайн үед хэрэгтнүүд тусгай хамгаалалттай газраас баавгай агнаснаа хүлээн зөвшөөрсөн тул тэдний “Сайга”, “Карбин”, “КСК” маркийн бууг хураан авсан байдаг. Энэ дагуу тэднийг Эрүүгийн хуулийн 203 дугаар зүйл, Ан агнуурын тухай хууль тогтоомжинд заасанчлан “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт болон хорiotтой үед хориглосон арга, зэвсэг хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, ан амьтанг зохих зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, тэжээсэн, гаршуулсан, тэгдээрийн түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн бол хөдөлмөрийн хөдсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх” хэмээн заасан байдаг.

Автобусны буудлуудыг асфальтаар хучжээ

“Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ-аас зам засвар, арчлалтын ажлыг хариуцан ажиллаж байна. Энэ сарын 15-ны өдөр тус байгууллагын зам засварын инженер, техникийн ажилтнууд Нарны зам дагуу Саруул төвийн баруун талд, 24-р байрны

урд шинээр хийж байгаа буцаж эргэх гарцын хэсэгт 25 метр урт авто замын хашлага, Сонгинохайрхан дүүргийн нэгдүгээр хорооллын арын замд шинээр хийж байгаа автобусны буудалд замын хашлага тус тус суулгаж, 28.6 тонн асфальтаар хучжээ. Мөн Улаанхуаран

орчимд шинээр хийж байгаа автобусны буудлын замыг 36.18 тонн асфальтаар хучсан бөгөөд Хүнсчдийн гудамж, “Алтан тариа” ХХК-ийн урд шинээр барьж байгаа автобусны буудлын суурийг тэгшилж, нягтруулан явган хүний замын хавтан суурилуулсан байна.

Энэ сарын 20-ноос дугаарын хязгаарлалт үйлчилнэ

Амралт зугаалгын улирал дуусч эцэдрлэг, ерөнхий боловсрол, их, дээд сургуулийн хичээл эхлэхтэй зэрэгцээд томоохон худалдааны төв, зах орчмыг тойрсон авто замын хөдөлгөөн ихэсч, замын түгжрэл үүсдэг. Үүнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг дарга өчигдөр автомашиныг улсын дугаараар ангилж, замын хөдөлгөөнд

оролцуулах тухай А/605 тоот тушаал гаргажээ. Тодруулбал, улсын дугаарын сүүлчийн орон тэгш тоогоор төгссөн автомашинтай жолооч наймдугаар сарын 20, 27-нд замын хөдөлгөөнд оролцох аж. Харин сондгой тоогоор төгссөн автомашинтай жолооч нар наймдугаар сарын 21, 28-нд замын хөдөлгөөнд

оролцох боломжтой. Тиймээс жолооч нар хязгаарлагдсан дугаартай автомашинтай зорчихгүй байх, цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх, аль болох нийтийн тээврийн хэрэгслийг сонгож замын хөдөлгөөнд оролцохыг Цагдаагийн газраас уриаллаа.

Гэмт хэргийн гаралт 0.3 хувиар буурав

Энэ оны эхний долоон сарын байдлаар нийт 16956 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 0.3 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа аж. Тодруулбал,

хүүхэд оролцсон гэмт хэрэг 117 буюу 18.3, бүлэглэн үйлдсэн хэрэг 192 буюу 14.1, эмэгтэй хүн оролцсон хэрэг 87 буюу 3.9, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 168 буюу 4.8 хувиар буурчээ.

Түүнчлэн аж ахуйн эсрэг гэмт хэрэг 332, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг 223-аар буурсан нь гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлжээ.

ЗАВСАРЛАГА



Б.ДАВАА

Бразилийн Рио-Де-Жанейро хотноо зуны олимпын XXXI наадамд дүрвэгсдийн багтай нийлээд 207 орны 11 мянга гаруй тамирчин спортын 28 төрөлд 306 багц медалийн төлөө өрсөлдөж байна. Олимп эхлээд эдүгээ 10 гаруй хонож буй бөгөөд сэтгэл догдуулсан торгон мөч,



Боксын рингэнд

ДАХИН НЭГ ТАМИРЧИН НУЛИМС УНАГАВ

үзэгчдийн дэмжсэн уухайн дуу үргэлжилсээр байгаа билээ. Спортын хэд хэдэн төрлийн аваргууд хэдийнэ тодорч, эдүгээ АНУ 80 гаруй медальтайгаар бусад орноо илт давуугаар тэргүүлж явна. Гэвч сүүлийн үед Олон улсын Боксын холбоо, боксын спортын шүүлттэй холбоотой гомдол тасрахгүй байгаа юм. Энэ байдал Риогийн Олимпод ч давтагдаа. Рио-2016 олимпын эрэгтэйчүүдийн 56

кг-ийн хүрэл медалийн төлөө тоглолт Лондоны олимпын хүрэл медальт, дэлхийн аварга Ирландын боксчин Майкл Конлан ОХУ-ын тамирчин Владимир Никитин нарын хооронд өрсөсөн юм.

Тоглолтын явцад Оросын тамирчны хуучин бэртэлнэсэдэрч, толгойноос нь цус гарсанаас гадна хөмсөг нь задарснаас болж тоглолтыг түр зогсоох гэх мэтээр М.Конлан бүх л үеийн

турш илүүрхэж байсан ч шүүгчид эцсийн мөчид В.Никитинд ялалт өгсөн нь цөс ихтэй Ирланд боксчинд таалагдсангүй. Шүүгч нар эхний үед Никитинийг ялсан хэмээн үзсэн бол хоёрдугаар үед ирланд залууд хожил өгсөн. Гэвч шийдвэрлэх гуравдугаар үед орос эрддавуусаналөгснөөр энэ тулаанд 2:1 эер шийдэгдсэн юм. Конлан ялагдсаныхаа дараа шүүгчид рүү дунд хуруугаа гозойлгон зүй бус үйлдэл гаргаж дэвжжэнээс буусан

хэдий ч хараал урсгасан хэвээр байсан юм. Конлан ялагдсанаар ирландчууд Афины олимпоос хойш анх удаа боксын төрлөөс олимпын медальгүй үлдэж байна. Тэрбээр "Олимпын хороо авлигад идэгдчихжээ. Тэд миний мөрөөдлийг надаас хулгайллаа. Тэд худалдагчид хайртай. Би дахиж ОУБХ-ны зохион байгуулж байгаа тэмцээнд оролцохгүй. Энэ тэмцээн Ази, европын аварга шалгаруулах биш, дэлхийн

аваргын тэмцээн ч биш, Олимп шүү дээ. Авлигад гүн гүнзгий идэгджээ. Би тэднийг ялзарсан гэж бодож байна. Иймэрхүү шударга бус зүйл холбоонд үргэлж болдог. Үүнийг хүн бүр л мэдэж байгаа" гэж сэтгүүлчдэд бухимдан ярьжээ. Боксын рингнээс цамцаа тайлсан чигтээ буусан залуу цахим ертөнцөд ч уур бухимдлаа илэрхийлж, бүр ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин руу хүртэл дайралт хийсэн юм.

М.Конлан твиттер хуудастаа Олон улсын Боксын холбооны хаягийг дурьдаж, "Путин та тэдэнд хэр ихийг төлсөн бэ" хэмээн жиргэсэн нь дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарлыг татлаа. Эдүгээ 24 настай боксчин залуу 2012 оны Лондонгийн Олимпоос хүрэл медаль хүртэж, өнгөрсөн жил Дэлхийн аварга болж байжээ. Харин энэ жилийн 31 дэх удаагийн Риогийн Олимпод аваргалах том зорилго тавьж, үүнийг биелүүлсний дараа мэргэжлийн бокст хөл тавих сонирхолтой байсан аж.

Гэвч хүрэл медалийн үзүүрээс атгаад алдсан тамирчин биеэ барьж дийлэлгүй бухимдлаа илэрхийлсэн нь Олимпын нэгэн элдэвтэй агшин байсан гэдэгтэй уншигчид маань санал нийлэх биз. Ямартай ч, Олон улсын боксын холбооноос түүнтэй холбоотой мэдэгдлийг мөн гаргасан байна.

Кристина Вогел суудалгүй дугуйтай тэмцээнээ дуусгав

Германы заалны дугуйн уралдааны тамирчин Кристина Вогелийн алтан медалийн төлөө уралдаан яах аргагүй Риогийн зуны олимпын торгон агшны нэг байлаа. Тэрбээр Олимпын алтан медалийн төлөө Их Британийн тамирчин Ребека Жэймстэй уралдсан юм. Улмаар уралдаан шувтарч бариа ойртох мөчид бүсгүйн дугуйны суудал салж унасан ч хурдаа алдалгүй дөрөвөгөө жийсээр өрсөлдөгчөөсөө дөрвөн секундын өмнө бариаы зурхайд хүрч Олимпын аварга боллоо. Эхний тойрогт тэрбээр өрсөлдөгчөө илт давуугаар тэргүүлж байсан. Харин дугуйн суудал салж унасны дараа хоёр дахь тойрог тамирчны хувьд тун чиг ягтуй даваа байсан нь гарцаагүй. Гэсэн ч туршлага, чадвараараа бүсгүй тэргүүлж чадлаа. Кристина Вогел "Хоёр дахь тойрогт суудал унасан хэдий ч түрүүлчихлээ. Ямар ч байсан хурдаа алдахгүйн тулд чадлаараа хичээсэн. Үнэхээр гайхалтай байлаа" хэмээн ялалтынхаа дараа өгүүлжээ. Харин Их Британийн тамирчин Ребека Жэймс мөнгөн медаль хүртсэн бол мөн тус улсын тамирчин Кэйти Марчанг хүрэл медаль хүртсэн. Ингэснээр Британи медалийнхаа тоог нэг мөнгө, нэг хүрлээр нэмлээ. Кристина Вогел эдүгээ 26 настай. Киргистаны Бишкек хотноо төрсөн бөгөөд түүнийг зургаан сартай байхад тэднийх Герман руу нүүж байжээ. Бүсгүй эдүгээг хүртэл Европ дэлхийн олон тэмцээнд оролцож байсан бөгөөд Залуучуудын ДАШТ-д зургаан удаа, Залуучуудын Европын аварга шалгаруулах тэмцээнд хоёр удаа түүрүүлж байсан юм.



Их Британийн "Golden couple"

Спортын ертөнцөд маш олон гайхалтай хосууд бий. Тэдний нэг бол Их Британийн дугуйн спортын тамирчин Жасон Кенни, Лаура Тротт нар. Хосууд ирэх есдүгээр сард хуримаа хийх юм. Харин тэдний хувьд Рио де Жанейро хотноо болж буй 31 дэх зуны Олимп тун ээлтэй болж өнгөрч байна. "Golden couple" гэх тодотголыг аль хэдийнэ британичуудаас хүлээгээд буй тэдний хувьд улсдаа оролцсон төрлөөсөө алт зулгааж, улсынхаа медалийн тоог 50-д хүргээд байгаа юм. Кеннигийн гаргасан амжилт Крис Хонгийн рекордтой тэнцэж, зургаан алтан медаль авсан бол Британийн хамгийн амжилттай яваа эмэгтэй тамирчдын нэг Тротт дөрөвдөх алтан медаль автаад байна.

Хорт хавдараа ялан дийлсэн Сантьяго Олимпод ч аваргалаа

Аргентины усан спортын тамирчин Сантьяго Ланге өнгөрсөн жил уушигны хорт хавдар тусч, нэг хэсгийг нь тайруулсан байдаг. Тэгвэл тамирчин залуу энэ оны Риогийн Олимпод Сесилия Карранза Саролитай нэг баг болж уралдан алтан медалийн энгэрээ мялаасан байна. Эдүгээ 54 настай, их спортын хөгшин тамирчдын тоонд багтах Сантьягогийн хувьд зургаа дахь удаагаа олимпод оролцож буй бөгөөд энэ удаагийн наадам карьерынх нь сүүлчийн томоохон тэмцээн байж ч мэднэ. Ланге хорт хавдартай гэдгээ өнгөрөгч онд анх мэдсэн байна. Тэрбээр 2004 болон 2008 оны Олимпод Карлос Эспинолатай нэг баг болж уралдаад хүрэл медаль хүртэж байсан чадварлаг тамирчин аж.

Вейд Ван Никерк дэлхийн рекордыг шинэчиллээ



Эрэгтэйчүүдийн 400 метрийн финалын

уралдаан болж өндөрлөлөө. Улмаар алтан медалийн эзэнээр Өмнөд Африкийн тамирчин Вейд Ван Никерк /Wayde van Niekerk/ 43.03 секундэд барианд орж, дэлхийн шинэ рекордыг тогтоосон юм. Эдүгээ 24 настай тэрбээр 2015 онд Бээжинд болсон тэмцээнд дэлхийн аварга болж байсан. Харин "Рио-2016" бол түүний хувьд анхны олимп. Тэрбээр оролцож буй анхны олимпоосоо ийнхүү алтан медальтан боллоо. Эрэгтэйчүүдийн 400 метрийн уралдааны мөнгөн медалийг Гренад улсын тамирчин Кириани Жеймс, хүрэл медалийг АНУ-ын тамирчин Лашон Мерритт хүртэв.

Германы дасгалжуулагч авто ослоор нас баржээ

Риогийн олимпын сэлүүрт завины уралдаанд оролцож буй Германы шигшээ багийн дасгалжуулагч зам тээврийн осолд орж, нас баржээ. Тодруулбал, Германы сэлүүрт завины шигшээ багийн дасгалжуулагч 35 настай Стефан Хензи өнгөрсөн долоо хоногт Рио де Жанейро хотноо осолд орж толгойдоо хүнд бэртэл авсан байна. Улмаар шархаа дийлэлгүй өчигдөр таалал төгсчээ. Цагдаагийн газраас мэдэгдсэнээр хэрэг энэ сарын 12-нд гарсан байна. Талийгаач таксинд сууж тамирчдын хотхон руу явж байх үед сууж явсан машин нь жолоодлогогүй болж хана мөргөсөн байна. Энэ ослын дараа тэрээр ухаангүй байдалтай эмнэлэгт хүргэгджээ. Одоогоор цагдаагийнхан ослын шалтгааныг тодруулахаар ажиллаж байна.

ДУУЛГАХ СОНИН

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн залуус улсын рекордыг шинэчиллээ

Дэлхийн чансаа олгох дартсын аварга шалгаруулах тэмцээнд "Монголын төмөр зам" ТӨХК-ийн баг тамирчид амжилттай оролцож, Хөгжлийн хэлтсийн Замын инженер Б.Болор-Эрдэнэ, Үйлдвэрлэл, техникийн хэлтсийн Вагоны инженер Б.Анхбаяр нар хосын төрөлд улсын рекордыг шинэчиллээ. Монголын сонгодог дартсын холбооноос зохион байгуулж буй энэ тэмцээнд Б.Болор-Эрдэнэ, Б.Анхбаяр нар 501 оноог 12 сумаар авсан амжилт үзүүлсэн байна. Мөн Хөгжлийн хэлтсийн Дохиоллын инженер Г.Дөлгөн ганцаарчилсан төрөлд тав дугаар байр, багаараа шигшээ 16 дугаар байрыг тус тус эзэлсэн байна. Дартсын спортоор хичээллээд удаагүй ч богино хугацаанд өндөр амжилт үзүүлсэн нь залуусын авьяас чадвар, багийн ажиллагаатай нягт холбоотой гэж Монголын сонгодог дартсын холбооныхон онцолж байсан юм.

Б.Болор-Эрдэнэ, Б.Анхбаяр
Хосын төрлийн улсын рекордыг 12 сумаар шинэчлэн тогтоолоо

TENGIS

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.



Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажиллагаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онц ноцтой гэмт хэргэгчид өршөөл үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гарас зугацлага 2016.08.19



Гарас зугацлага 2016.08.19



Гарас зугацлага 2016.8.19



Гарас зугацлага 2016.08.26



Гарас зугацлага 2016.08.02